

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-135
АГААРЫН ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА - БАГТААМЖ БАГАТАЙ ОНГОЦ БА
НИСДЭГ ТЭРЭГ

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

135.1 Зорилго

Энэ дүрмээр дараах агаарын хөлгүүдээр гүйцэтгэх агаарын тээврийн үйл ажиллагаа ба арилжааны тээврийн үйл ажиллагааг зохицуулна:

- (1) Нисэх багийнсуудлыг тооцохгүйгээр 12 болон түүнээс цөөн зорчигчийн суудалтай, хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин 5700 кг эсхүл түүнээс бага жинтэй, нэг хөдөлгүүртэй хэрэглэлийн нислэгийн дүрэмийн дагуу ашиглаж байгаагаас бусад онгоц;болон
- (2) Нисдэг тэрэг.

135.3 Тодорхойлолт

Агаарын үйл ажиллагаа гэж нэг хөдөлгүүртэй онгоцоор хэрэглэлийн нислэгийн дүрэмийн дагуу ашиглаж байгаагаас бусад дараах агаарын хөлгүүдээр гүйцэтгэж байгаагаарын тээврийн үйл ажиллагаа эсхүл арилжааны тээврийн үйл ажиллагааг.

- (1) Нисэх багийнсуудлыг тооцохгүйгээр 12 болон түүнээс цөөн зорчигчийн суудалтай, хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин 5700 кг эсхүл түүнээс бага жинтэй онгоц; эсхүл
- (2) Нисдэг тэрэг.

Агаарын үйл ажиллагааны гэрчилгээг гэж агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эсхүл ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг;

Батжуулалт гэж хувь хүн шинэхэн авсан нисгэгчийн нислэгийн үйл ажиллагааны мэдлэг, ур чадварыг дадлага ба нислэгийн үед дадлага туршлага хуримтлуулах байдлаар мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг;

Үйл ажиллагааны заавар гэж нөхцөл байдал өөрөөр заагаагүй бол ИНД 119.81 эсхүл 119.125-д шаардсан үйл ажиллагааны зааврыг;

Нисдэг тэрэгний гадна ачаалал гэж олс, тор, татлаганы тусламжтайгаар хүн болон нисдэг тэрэгний гадна доод талд бэхлэн тээвэрлэх эсхүл татан авахыг;

Агаарын үйл ажиллагааныг гэрчилгээ эзэмшигчг гэж ИНД-119-ийн дагуу гэрчилгээжиж, агаарын үйл ажиллагаа хийх эрх олгогдсон аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнийг;

Хөөрөлтийн бүдүүвч, нислэгийн чиглэл, хөөрөлт үйлдэх зай, хөөрөлтийн гүйлт гэж тухайн онгоцыг гэрчилгээжүүлсэн дүрэмд заасан утгатай адил тодорхойлолтуудыг;

Босго гэж саадаас чөлөөтэйойртолтын гадаргуу хөөрөх буух зурвасын гадаргуутай 1:20 харьцаатай огтлолцож буй цэг.

135.5 Хууль, дүрэм, заавар ба журам

Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ эзэмшигчийннислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтнууд, эсхүл гэрээт ажилтнуудад иргэний нисэхийн хууль, дүрэм, гэрчилгээ эзэмшигчийн заавар, журмуудын тухайн үйл ажиллагаатай холбогдолтой хэсгүүдийг танилцуулж, дагаж мөрдүүлэх үүрэгтэй.

135.7 Заавар болон журмыг дагаж мөрдөх

Нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд бүр гэрчилгээ эзэмшигчийн зохих заавар, журамд заасны дагуу тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх эрхийггэрчилгээ эзэмшигчээс олгогдсон байна.

135.9 Нисэх багийн гишүүний шалгалт өгсөнөөр тооцох (Crew member grace provisions) тооцох

Хэрэв нисэх багийн гишүүн нь энэ дүрмийн Бүлэг I эсхүл J-д шаардсан нислэгийн ур чадварыг шалгах нислэгээр эсхүл шалгалтаар өгөх хугацаанаас 60 хоногийн дотор амжилттай өгсөн тохиолдолд ур чадварын шалгалт өгсөнд тооцно.

135.11 Нөөц

135.13 Зорчигчдод аюулгүй ажиллагааны мэдээлэл өгөх

Арилжааны тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь ИНД 91.211-д заасан шаардлагаас гадна зорчигч бүрд тухайн нислэгийн онцлогт тохирсон ослын болон аюулгүй ажиллагааны талаарх нэмэлт мэдээлийг заавал танилцуулсан байна.

Б БҮЛЭГ.НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

135.51 Нөөц

135.53 Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

(a) Гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглаж байгаагаарын хөлөг бүр нь стандарт ангиллын хүчин төгөлдөр нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.

(b) Гэрчилгээ эзэмшигчийн арилжааны тээврийн үйл ажиллагаанд ашиглаж байгаагаарын хөлөг нь:

- (1) стандартангиллын хүчин төгөлдөр нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэйэсхүл
- (2) агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу зөвшөөрөгдсөн нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх боломжтой хязгаарлагдмал ангиллын хүчин төгөлдөр нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.

135.55 Багийн гишүүдийн нийтлэг хэл

Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийг бататгасан байна:

- (1) нисэх багийн гишүүд нийтлэг нэг хэлээр ойлголцох ба нисэх багийн аль нэг гишүүн Англи хэлээр холбоо барих боломжтой байх болон
- (2) нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа бүх ажилтан гэрчилгээ эзэмшигчийн холбогдох зааврыг тухайн бичсэн хэлээр нь ойлгох чадвартай байна.

135.57 Нислэгийн өмнөх бэлтгэл ба нислэгийн төлөвлөлт

(a) Гэрчилгээ эзэмшигч нь зөвшөөрөгдсөн нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхээсөмнө агаарын хөлгийн даргатөлөвлөсөн нислэгт бэлтгэх үед тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой зохих шаардлагатай мэдээллээр бүрэн хангасан байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах агаарын үйл ажиллагаануудын өмнө:

- (1) агаарын тээврийн үйл ажиллагаа болон
- (2) зорчигч эсхүл ачааг алслагдмал орон нутгийн аэродром руу эсхүл тухайн буудлаас тээвэрлэх арилжааны тээврийн үйл ажиллагааг зохих зөвшөөрлийн дагуу гүйцэтгэхээс өмнө ИНД 91.307 (c) эсхүл ИНД 91.407-д заасны дагуу төлөвлөсөн нислэгт бэлтгэх уулзалтын шаардлагыг хангах болон хэрэв агаарын хөлгийн дарга нислэгийн төлөвлөгөөг бэлдээгүй бол тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой нислэгийн төлөвлөгөөг агаарын хөлгийн даргад танилцуулсан байх үүрэгтэй.

(c) Энэ хэсгийн(b)-д заасан нислэгийг гүйцэтгэхээс өмнө ИНД 91.307 (c) шаардлагын дагуу ИХНД-ээр гүйцэтгэхээр нислэгийн төлөвлөгөөг бэлтгэж байгаа бол буулт хийх аэродром руу “SARTIME” хугацаанд нислэгийн олон хувилбар бүхий нислэгийн маршрут гаргаж болно.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь ИХНД-ээр холбоо НХҮ үзүүлдэггүй (холбоо барьдаггүй)аэродром руу нислэг гүйцэтгэх гэж байгаа дараах зүйлүүдийг бататгана:

(1) энэ хэсгийн(b) заасан нислэгийн төлөвлөгөө бэлтгэж байгаа бол дараагийн НХҮ-ний байгууллагатай холбоо барих “SARTIME” хугацааг тогтоосон; эсхүл

(2) хэрэв ИНД 119.73(b) эсхүл ИНД 119.121(b)-д заасны дагуу нислэг дагах үйлчилгээ (Flight following Service) авч байгаа бол холбоо барих хугацааг тогтоож өгсөн байна.

(e) Энэ хэсгийн(f) зааснаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь (b) заасан нислэгийн төлөвлөгөөг бэлтгэж холбогдох НХҮ-ний байгууллагад хүргүүлсэн байна.

(f)ИНД 91.307 (a)(1) зааснаас бусад тохиолдолд нислэгийн төлөвлөгөөг НХҮ-ний байгууллагад хүргүүлэх шаадлагагүй хэрэв:

(1) ИХНД-р нислэг гүйцэтгэж байгаа; болон

(2) ИНД 119.73 (b) эсхүл ИНД 119.121(b)-д заасны дагуу нислэг дагах үйлчилгээ (Flight following Service) авч байгаа; болон

(3) ИНД 119.73 (b)-н хүрээнд эсхүл 119.121(b)-д нийцэж байгаа; болон

(4) Агаарын хөлгийн дарга НХҮ-ний байгууллагын хобогдох давтамжийг сонсож, хянаж байгаа үед.

(g) ИНД 91.307 (a),ИНД 91.407 (a)(1)-д агаарын хөлгийн дарга нислэгийн төлөвлөгөөг НХҮ-ний байгууллагад хүргүүлнэ гэж заасныг үл харгалзан энэ хэсгийн(e)-д заасан хүрээнд гэрчилгээ эзэмшигч нислэгийн төлөвлөгөөг бэлтгэж холбогдох НХҮ-ний байгууллагад хүргүүлэх болон агаарын хөлгийн даргад нислэгийн төлөвлөгөөний дагуу зөвлөмж өгсөн байна.

135.59Авран хамгаалах тоног төхөөрөмжийн тухай мэдээлэл

(a) Гэрчилгээ эзэмшигч нь Эрэн хайх, авран туслах мэдээлэл зохицуулах төвтэй холбоо барихад зориулсан мэдээллийг агаарын хөлөгт байгаа авран хамгаалах тоног төхөөрөмжүүд дээр байрлуулсан байна.

(b) Далайн эргээс 18 км /10nm/зайд үйлдэх нислэгийн үед энэ хэсгийн(a)-д заасан мэдээлэлд дараах зүйлүүдийг нэмж оруулсан байна:

(1) аврах завины тоо ширхэг, өнгө төрөл маяг; болон

(2) дохионы пуужин байгаа эсэх; болон

(3) эмнэлгийн яаралтай тусламжийн болон цэвэр усны хангамжийн талаарх мэдээлэл; болон

(4) Агаарын хөлгийн дарга НХҮ-ний байгууллагын хобогдох давтамжийг сонсож, хянаж байгаа үед.

135.61Түлш

(а) Гэрчилгээ эзэмшигчнь агаарын хөлгийн төлөвлөсөн нислэг, нислэгийн явц дахь нислэгийн төлөвлөгөөний өөрчлөлтийн үед хүрэлцэхүйц хангалттай нөөц түлш авч байх зорилготой түлшээр сумлах заавартай байна.

(b)Түлшээр сумлах зааварт шаардлагатай түлшийг тооцоолохдоо дараах зүйлүүдийг үндэслэнэ:

(1) агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн зааварт тусгагдсан, эсхүл тэдгээрийг ашиглан боловсруулсан, тухайн агаарын хөлгийн маягийн гэрчилгээнд бичигдсэн өгөгдэхүүнтэй тохирсон журам, хүснэгт, графикууд; болон

(2) төлөвлөгдсөн нислэг гүйцэтгэх үеийн шаардлага, нөхцлийг.

(c)Гэрчилгээ эзэмшигч нь нислэгт шаардлагатай түлшийг тооцоолохдоо дараах хүчин зүйлүүдийг харгазана:

(1) явгалалтын үед хийгдэх түлш;

(2) аялалд зарцуулах түлш;

(3)дараах түлшүүдээс бүрдсэн нөөц түлш:

(i) гэнэтийн үед ашиглах түлш; болон

(ii) нөөц аэродром руу нисэхэд шаардагдах түлш; болон

(iii) нөөц аэродромд нисэн очсоноос хойш 30 минутаас доошгүй хугацаанд нисэх эсхүл (if an alternate is not required, at the destination aerodrome at holding speed in ISA conditions)түлш; болон

(iiii) нислэгийн төрлөөс шалтгаалан нэмэлт түлш.

(d)Нислэгийн төлөвлөгөө эсхүл маршрутыг дахин төлөвлөж байгаа ажилтан нь энэ хэсгийн(а)-д заасан түлшээр сумлах зааврын шаардсаныг дагаж мөрдөнө.

135.63Бүхээгийн шалгах хуудас

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаанд шаардлагатай ердийн болон онцгой байдлын үед ашиглах тухайн агаарын хөлөгт нийцсэн бүхээгийн шалгах хуудсыг нисэх бүрэлдэхүүн ашиглахад бэлэн байлгана.

(b) Нисэх багийн гишүүд нь ердийн болон онцгой байдлын үед тухайн агаарын хөлгийн Нислэгийн зааварт нийцсэн бүхээгийн шалгах хуудсыг ашиглах зохих дадлага туршлагатай байна.

135.65 Зорчигчид тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

(a) Агаарын үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа ажилтан нь:

(1) согтууруулах ундаа, мансууруулах бодис, эм тариахэрэглэсэний улмаас агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа болон зорчигчдод аюул учруулж болзошгүй аливаа этгээдийг тээвэрлэхээс татгалзах эсхүл шаардлагатай гэж үзвэл агаарын хөлгөөс буулгах; болон

(2) өвчтэй болон хөгжлийн бэрхшээлтэй зорчигчийг тохиромжтой суудалд суулгах болон ослын үед шаардлагатай тусламжийг үзүүлэх; болон

(3) хууль, хяналтын байгуулагын ажилтны харгалзаж яваа зорчигчийг гэрчилгээ эзэмшигчийн холбогдох зааварт заасан журмын дагуу бусад зорчигчдод эсхүл агаарын хөлөгт аюул учруулахгүйгээр урьдчилан бэлтгэж тээвэрлэх.

(b) Энэ хэсгийн (a)(1)-г үл харгалзан, эрэн хайх болон түргэн тусламжийн зорилгоор үйлдэх нислэгт, согтууруулах ундаа, эм тарианд мансуурсан, бие авч явах чадваргүй, агаарын хөлгийн болон зорчигчдын аюулгүй байдалд хор нөлөө үзүүлж болзошгүй аливаа этгээдийг тээвэрлэгчийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авч болзошгүй эрсдлийг бууруулсан тохиолдолд тээвэрлэж болно.

135.67 Нөөц

135.69 Нисэх багийн бүхээгт нэвтрэх

(a) Энэ хэсгийн (b)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээдийг нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн бүхээгт нэвтрэх, нисгэгчийн суудалд эзлэхийг хориглоно.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь аливаа этгээдийг дор дурдсанаас бусад тохиолдолд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн бүхээгт нэвтрэх, нисгэгчийн суудалд эзлэхийг хориглоно:

(1) нисэх багийн гишүүн; эсхүл

(2) ИНЕГ-ын даргын эрх бүхий төлөөлөгч:

(i) гэрчилгээ эзэмшигч болон агаарын хөлгийн даргаас зөвшөөрөл олгогдсон; болон

(ii) албан үүргээ гүйцэтгэж байгаа.

135.71 Нислэгийн бичлэгийн хэрэгсэлд тавигдах шаардлага

(a) Нисэх багийн гишүүн бүр нь ИНД135.367-д шаардсан бүхээгийн дуу чимээ бичигчийг (cockpit-voice recorder):

(1) хөдөлгүүр асаахаас өмнө шалгах хуудас уншихаас эхлэн нислэгийн дараах шалгах хуудас дуусах хүртэлтасралтгүй ажиллуулна; болон

(2) хэрэвнисдэгтэргийг чихэвчний болон гар микрофоноосбичиххэрэгсэлээртоноггосонбол гармикрофоныг 3000 метр /10000 feet/-ээс нам өндөрт ашиглана; болон

(3) хэрэвбүхээгийн дуу бичигч нь бичлэг арилгагчтай бол нислэгийн сүүлчийн 30 минутын бичлэгээс өмнөх бичлэгийг арилгадаг байна гэдгийг бататгана.

(b) Нисэх багийн гишүүн бүр нь ИНД 135.369-д шаардсан нислэгийн өгөгдөхүүн бичигчийг (flight data recorder):

(1) нисдэг тэрэг хөөрөлт үйлдэхээс эхлэн буулт хүртэл тасралтгүй ажиллуулна; болон

(2) нисдэг тэрэгний бичигдсэн өгөгдөхүүнүүд дараагийн 10 цагийн нислэг үйлдэх хүртэл хадгалагддаг байх; болон

(3) нислэгийн өгөгдөхүүн бичигч эсхүл нислэгийн өгөгдөхүүн бичигч системийг шалгах үед бичигдсэн өгөгдөхүүний 1 цагаас илүү бичлэгийг арилгаж болохгүй.

(4) энэ хэсгийн (b)(3)-т заасны дагуу бичлэг арилгахдаа:

(i) шалгах үед байгаа хамгийн хуучин бичлэгийг сонгох; болон

(ii) техник үйлчилгээний холбогдох баримт бичигт тэмдэглэнэ.

135.73 Түлшээр сумлах болон түлш юүлэх ажиллагаа

(a)ИНД 119-н дагуу агаарын тээврийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД 91.53-н шаардлагыг үл харгалзан зорчигчдыг агаарын хөлөгт суулгаж, эсхүл агаарын хөлгөөс буулгаж байгаа үед хэрэв гэрчилгээ эзэмшигчийн зааварт заасны дагуу агаарын хөлгийн аюулгүй ажиллагааны зааварчилгыг багийн гишүүд өгсөн бол 3.1C эсхүл 3.1D ангиллын түлшээр сумлах болон түлш юүлэх ажиллагааг гүйцэтгэж болно.

(b)ИНД 119-н дагуу агаарын тээврийн гэрчилгээ эзэмшигчийн ажилтан аль нэг хөдөлгүүр нь ажиллаж байгаа үед агаарын хөлгийг 3.1C эсхүл 3.1D ангиллын түлшээр сумлах болон түлш юүлэх ажиллагааг хэрэв дор дурдсан нөхцлүүд хангагдсан үед гүйцэтгэж болно:

(1) гэрчилгээ эзэмшигчийн зааварт заасны дагуу агаарын хөлгийн аюулгүй ажиллагааны зааварчилгыг багийн гишүүд өгсөн бол: болон

(2) агаарын хөлгийн дарга түлштэй холбоотой бүх асуудалд хариуцлага хүлээх бол.

135.75 Нөөц

135.75 Аэродромын ашиглалт

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлгөөр дараах нөхцлүүд биелэхгүй тохиодолд тус аэродромыг хөөрөлт буулт хийхээр ашиглахгүй:

(1) аэродромын үзүүлэлтүүд, саадын хязгаарлалт, ил харааны хэрэгсэл нь дараах зүйлд нийцэж байгаа бол

- (i) ашиглагдаж байгаа онгоцны үзүүлэлтэнд тохирсон байна: болон
- (ii) цаг уурын минимум нөхцлөөр ашиглагддаг байна.

(2) хэрэв тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаа нь Монгол руу эсхүл Монголоос гадагшаа нисэж байгаа бол

(i) Монголд ашиглагдаж байгаа аэродромуудын ХБЗ нь энэ дүрмийн Хавсралт А.1-д заасан зурвасны төгсгөлийн аюулгүй бүстэй (RESA) байна.

(iii) Монгол улсаас гадна ашиглагдаж байгаа аэродромуудын ХБЗ-ны төгсгөлийн аюулгүй бүс (RESA) нь хамгийн багадаа зурвасны эцсийн давхцал (overrun end) цэгээс 150м сунгасан байх эсхүл инженеринг эквивалент нь ИНЕГ-ын Даргаас хүлээн зөвшөөрөгдсөн байна.

(iv) хэрэв ХБЗ нь зурвасны төгсгөлийн аюулгүй бүс (RESA) эсхүл (а) (2) (iii)-д заасан инженеринг эквивалент байхгүй бол гэрчилгээ эзэмшигч агаарын хөлгийн хөөрч буух тооцоолол хийхдээ ХБЗ-ны зарлагдсан зайг багасгаж нь зурвасны төгсгөлийн аюулгүй бүс (RESA) эсхүл (а) (2) (iii)-д заасан инженеринг эквивалент тооцно.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь ашиглаж байгаа нисдэг тэрэг хөөрч буухдаа ИНД 91-н шаардлага хангасан хелипорт ашиглаж байгааг бататгана.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь Монгол улсын AIP-д нистлээгүй аэродромд нислэг үйлдэх бол дараах бүртгэл, мэдээлэлтэй байна:

(1) тухайн аэродромын өгөдөхүүн; болон

(2) аэродромын нөхцөл байдал тухайн нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй гэдгийг бататгасан журам; болон

(3) аюулгүй ажиллагааны болон шаардлагатай бусад тоног төхөөрөмжүүдийн нөхцөл байдал тухайн нислэгийн нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй гэдгийг бататгасан журам; болон

(4) тухайн аэродромын ашиглалтын хязгаарлалтууд.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь өдрийн цагт ИХНД-ээр нислэг үйлдэх онгоцоор дараах шаардлага хангаагүй талбайд хөөрөлт, буулт үйлдэж болохгүй:

(1) ашиглаж байгаа хөөрөх буух зурвас нь:

(i) онгоцны үндсэн хөл ангийн гадна талын хоёр дугуйн хоорондох зайнаас 2 дахин өргөн; болон

(ii) хөөрөлт буулт үйлдэх тохиромжтой шулуун, зурвасны гадаргуу нь тэгш байна.

(2) ХБЗ-ны өргөн нь онгоцны далавчны /размах/-аас 2.5 дахин болон түүнээс дээш, эсхүл 30 метрийн аль ихээр тогтоосон байна.

(е) Гэрчилгээ эзэмшигчийн нь энэ хэсгийн(d)-гийн дагуу нислэг үйлдээгүй онгоц дараах тохиолдолд аливаа талбайд хөөрөлт, буулт үйлдэхгүй:

(1) ашиглах гэж буй онгоцны хувьд тухайн аэродромын харгалзах код энэ дүрмийн Хавсралт С-н Хүснэгт 1-д тодорхойлогдоогүй: болон

(2) ХБЗ-ны хувьд өргөн нь тухайн онгоцны харгалзах код энэ дүрмийн Хавсралт С-н Хүснэгт 2-д тодорхойлогдох өргөнөөс бага бол: болон

(3) ХБЗ-ны хамгийн бага өргөн нь ИНД 139 Хавсралт С-н Хүснэгт С-1-д тодорхойлогдоогүй бол.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь энэ хэсгийн(d) болон (е)-г үл харгалзан, аль нэг онгоцны маягийн хувьд (d) болон (е)-д зааснаас бага өргөнтэй ХБЗыг дараах нөхцөлд ашиглаж болно.

(1) зурвасны хамгийн бага өргөнийг тухайн онгоцны Нислэгийн зааварт шалгах нислэгээр тодорхойлсон гэж бичигдсэн бол: эсхүл

(2) ХБЗ-ны хамгийн бага өргөнийг ИНЕГ-н дарга хүлээн зөвшөөрсөн бол.

135.79 Нөөц

135.81 Нэг хөдөлгүүртэй агаарын хөлгөөр ХНД-ийн дагуу нислэг үйлдэх

Аливаа этгээд нь нэг хөдөлгүүртэй агаарын хөлгөөр ХНД-ийн дагуу зорчигч тээврийн нислэг үйлдэж болохгүй.

135.83 Үйл ажиллагааг хязгаарлах буюу түр зогсоох

Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн талаар мэдсэн тохиолдолд тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэлх хугацаанд нислэгийн үйл ажиллагаандаа хязгаарлалт хийх, эсхүл үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоох арга хэмжээг авна.

135.85ИХНД-ээр үйлдэх нислэгийн хамгийн бага өндөр

(a) ИНД 91.311 (с)-н шаардлага нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн даргад хамаарахгүй болно.

(b) Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн дарга нь дараах тохиолдолд ИНД 91.311 (с)(4)-н заалтыг үл харгалзан ойртолт, хөөрөлт болон нислэгийн бусад маневрыг хүн, машин техник, барилга байгууламжаас 150 метр /500 feet/-ийн радиус дотор газрын гадаргуугаас дээш 150 метр /500 feet/-с нам өндөрт гүйцэтгэж болно.

- (1) тухайн нислэгийн төлөвлөгөө нь түүнд оролцох байгууллага, хүмүүсийн оролцоотой хийгдсэн бол: болон
- (2) нислэгийн үйл ажиллагаа нь аливаа хүн ба эд зүйлд аюул учруулахааргүй бол: болон
- (3) энэ хэсгийн (1)-д заасан төлөвлөгөөний дагуу нислэгийн үйл ажиллагаанд оролцох байгууллага, хүмүүст урьдчилан мэдээлэл хийсэн бол.

135.87 Усан дээгүүрх нислэг

- (a) Усан дээр гулсаж эсхүл авторотацийн үед буух зай нь эргээс 18,6 км /10 nm/-ээс дээш тохиолдолд, усан дээгүүр нислэг гүйцэтгэх аливаа этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:
 - (1) агаарын хөлөгт байгаа бүх хүмүүс багтахуйц аврах завьтай байх: болон
 - (2) зорчигч бүр аврах хантааз өмссөн байх.
- (b) Авторотацийн үед буух зай нь эргээс 18,6 км /10 nm/-ээс дээш тохиолдолд, нэг хөдөлгүүртэй нисдэг тэргээр усан дээгүүр нислэг гүйцэтгэх аливаа этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:
 - (1) Нисдэг тэрэг ажиллагаатай хийлдэг төхөөрөмжөөр тоноглогдсон байх: болон
 - (2) зорчигч бүр тусгай хамгаалалтын хувцас /immersion suit/ өмссөн байх.

135.89 Нөөц

135.91 Онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө

- (a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгт болон газар дээрх онцгой нөхцөл байдлын үед хүмүүс гэмтэж бэртэх магадлалыг аль болох бууруулахад чиглэсэн онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үед гарах онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг тусгасан байх ба үүгээр хязгаарлагдаж болохгүй:
 - (1) нислэгийн үйл ажиллагааны төрөл болон аялалын нийт зай; болон
 - (2) аэродромын газрын хангалт, тоноглол; болон
 - (3) орон нутгийн онцгой байдлын авран хамгаалах үйлчилгээ; болон
 - (4) НХҮ-ний байгууллагын хангалт, тоноглолууд; болон
 - (5) Агаарын хөлгийн маяг, суудлын тоо, төлбөрт ачаалал.
- (c) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгт үүссэн онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг тусгасан байнг:
 - (1) нислэгт үүссэн онцгой нөхцөл байдлын үед арга хэмжээ авах, шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь дараах зүйлүүдийг бататгана:
 - (i) үүссэн онцгой нөхцөл байдлын талаар агаарын хөлгийн даргад мэдээлэл зөвлөмж өгөгдсөн эсэхийг; болон
 - (ii) агаарын хөлгийн даргын шийдвэрийг хүлээн авсан эсэхийг; болон
 - (iii) шийдвэрийн талаар бичлэг, тэмдэглэл хийсэн эсэхийг.

(2) энэ хэсгийн (с) (1)-д заасны дагуу агаарын хөлгийн даргатай холбоо тогтоож чадаагүй тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь дараах зүйлийг бататгана:

- (i) авран хамгаалах ажиллагаа зарлагдсаныг; болон
- (ii) тухайн нөхцөл байдалд шаардлагатай арга хэмжээ авагдаж байгааг.

(с) Гэрчилгээ эзэмшигч нь онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу холбогдох хүмүүсийг шаардлагатай сургалтанд хамруулсныг, сургалтанд хамрагдсан хүмүүс нь онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу ажиллах чадвартай гэдгийг бататгана.

135.93 Хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүрх нислэг

(а) ИНД 91.311 (а)(1)-ийн шаардлагыг үл харгалзан нисдэг тэрэгний дарга нь хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүр, хамгийн өндөр аливаа саад эсхүл газрын гадаргаас дээш 300 м /1000 feet/-ээс нам өндөрт ямар нэг байгууламжаас 600 метр /2000 feet/ радиус дотор дараах шаардлагыг хангасан нөхцөлд нислэг үйлдэж болно:

(1) дараах зүйлүүдийг тусгасан нислэгийн төлөвлөгөөтэй бол:

- (i) нислэгийн өндөр өндөр болон нислэг үйлдэх газар нутгийг тэмдэглэсэн зурагтай; болон
- (ii) хүн болон эд зүйлд хохирол учруулахгүй байхыг бататгасан журамтай; болон
- (iii) НХУ-ний байгууллагад зайлшгүй шаардлагатай мэдээллийг өгсөн; болон
- (iv) тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад албан ёсоор мэдэгдэж, орон нутгийн эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх бол.

(а) Энэ зүйлийн (а)-гийн дагуу дагуу нислэгийн үйл оролцож байгаа агаарын хөлгийн дарга нь (а)(1)-д заасан нислэгийн төлөвлөгөөг дагаж мөрдөнө.

135.95 Нисдэг тэрэгний татлагат ачаалал

(а) Нисдэг тэргээр агаарын тээврийн үйл ажиллагаа хийж байгаа агаарын хөлгийн дарга нисдэг тэрэгний гадна татлагат ачаалал хийж зөөвөрлөхийг хориглоно.

(b) Нисдэг тэргээр арилжааны тээврийн үйл ажиллагаа хийж байгаа агаарын хөлгийн дарга ИНД 133.53-н шаардлагыг үл харгалзан дараах тохиолдлуудад нисдэг тэрэгний гадна татлагат ачаалал хийж зөөвөрлөж болно:

- (1) татлагат ачааллаар зөөвөрлөх ачаа нь агаарын хөлгийн бүхээгт байгаа зорчигчдынх бол; болон
- (2) ИНД 133-т заасан гадна ачаалалтай нисдэг тэрэгний нислэгийн үйл ажиллагааны шаардлагуудыг хангаж байгаа бол; болон
- (3) нислэг нь өдрийн цагаар, ИХНД-ийн дагуу үйлдэгдэж байгаа бол.

(4) тухайн нисдэг тэрэг нь хөрөөлт буулт хийх үед хамгийн их боломжит хөдөлгүүрийн чадлаас 10%-иас доош хувиар бага хөдөлгүүрийн чадлыг ашиглаж байгаа бол.

БҮЛЭГ С. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ БОЛОН ЦАГ УУРЫН ШААРДЛАГУУД

135.151 Зорилго

Энэ бүлгийн зорилго нь ИХНД болон ХНД-ээр нислэг гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд тавигдах цаг уурын шаардлагууд болон тэдгээрийн зохицуулах журмыг тогтооход оршино.

135.153 Цаг уурын мэдээ

(а) ИХНД-ийн дагуу нислэгийг гүйцэтгэж байгаа этгээд нь тухайн нислэгт зориулангэрчилгээ эзэмшигч болон агаарын хөлгийн даргаас хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаас өгөгдсөн найдвартай, нарийвчлалтайцаг уурын мэдээг ашиглан нислэгийн төлөвлөж, гүйцэтгэх болон хяналт тавина.

(b) ХНД-ийн дагуу агаарын тээврийн нислэгийг гүйцэтгэж байгаа этгээд нь дараах байгууллагаас авсан цаг уурын мэдээг ашиглан нислэгүүдийг төлөвлөх, гүйцэтгэх болон хяналт тавихад ашиглана:

(1) энэ зүйлийн(с)-н дагуу гүйцэтгэж байгаа нислэгийн маршрут хэсэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрт харъяалагдаж байгаа бол цаг уурын байгууллага нь ИНД 174-н дагуу гэрчилгээжсэн: эсхүл

(2) нислэг гүйцэтгэж байгаа аэродром нь Монгол Улсын нутаг дэвсгэрт харъяалагдахгүй байгаа бол нисэхийн цаг уурын байгууллага нь:

(i) тухайн аэродромын нисэхийн цаг уурын байгууллага нь ИНД 174-д заасан шаардлагуудад нийцсэнстандартын хангасан; болон

(ii) ИКАО гишүүн улсаас нисэхийн цаг уурын байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

(с) Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ХНД-ийн дагуу үйлдэгдэж буй нислэгийн хувьд агаарын хөлгийн дарга нь буух ойртолт болон буулт үйлдэхдээ ИНД 174.6-ийн дагуу хангагдах цаг агаарын мэдээг үндслэл болгоно.

135.155 ИХНД-ээр нислэг үйлдэх цаг уурын нөхцөл

(а) ИХНД-ээр нислэг гүйцэтгэх этгээд нь нислэг үйлдэх маршрутын дагуух, эсхүл тухайн нислэгийнмаршрутын тодорхой хэсэг дэх цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээнд, энэ зүйлийн (b), (c), (d) болон (e) ИНД 91-д заасан ИХНД-ийн хязгаарлалт хангагдаагүй тохиодолд ИХНД-ээр нислэг үйлдэхгүй.

(b) Агаарын хөлгийн дарга хяналттай агаарын зайн гадна онгоцоор цаг уурын дараах нөхцлүүдэд ИХНД-ээр нислэг үйлдэж болно:

(1) газрын гадаргуугаас дээш 300 м /1000 feet/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 5 км–ээс багагүй байх үед; болон

(2) хэрэв шөнийн нислэг үйлдэж байгаа бол газрын гадаргуугаас дээш 900 м /3000 feet/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 16 км-ээс багагүй байх үед.

(с) Агаарын хөлгийн дарга хяналттай агаарын зайн гадна нисдэг тэргээр цаг уурын дараах нөхцлүүдэд ИХНД-ээр нислэг үйлдэж болно:

(1) газрын гадаргуугаас дээш 200 м /600 feet/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 1500 м-ээс багагүй байх үед; болон

(2) хэрэв шөнийн нислэг үйлдэж байгаа бол газрын гадаргуугаас дээш 600 м /2000 feet/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 16 км-ээс багагүй байх үед.

(d) Агаарын хөлгийн дарга нь нисдэг тэргээрарилжааны агаарын тээврийн нислэгийг дараах нөхцлүүдэд ИХНД-ээр нислэг үйлдэнэ:

(1) нислэгийн маневруудыг үйлдэхдээ өөр бусад агаарын хөлгүүдийн хөдөлгөөний ажиглан, аливаа саадтай мөргөлдөхөөс сэргийлнэ; болон

(2) алслагдсан аэродромд нислэг үйлдэж байгаа бол цаг агаарын хувьд газрын гадаргуугаас дээш 200 м /600 feet/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 1500 м-ээс багагүй байх үед; болон

(3) алслагдсан аэродромоос бусад аэродромын хувьд, нислэгийн хамгийн дээд өндрөөс доош газрын гадаргуу харагдахуйц болон сэмжин үүлнээс бага үүлний дээгүүр; болон

(4) хэрэв шөнийн нислэг үйлдэж байгаа бол газрын гадаргуугаас дээш 600 м /2000 feet/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 5 км-ээс багагүй байх үед.

(d) Агаарын хөлгийн дарга нь дараах шаардлагуудыг хангаагүй тохиолдолд сэмжин үүлний дээгүүр ИХНД-ээр нислэг үйлдэхгүй:

(1) агаарын хөлөг нь ХНД-ээр нислэг үйлдэх шаардлагыг хангасан ба нисэх баг нь хэрэглэлийн нислэгийн хүчин төгөлдөр зэрэглэлтэй байх /нислэгт шаардагдах хамгийн цөөн бүрэлдэхүүнтэй нисэх баг болон ХНД-ийн дагуух нислэгт тавигдах шаардлагуудыг хангасан/; болон

(2) ХНД-ээр үйлдэх нислэгт шаардлагатай радио навигацийн болон бусад хэрэглэл, тоног төхөөрөмжүүд нь ажиллагаатай байх; болон

(3) хэрэглэлийн тусламжтайгаар ойртолт үйлдэн буух боломжтой аэродром руу ХНД-ээр нислэгийг гүйцэтгэх боломжтой радио навигацийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон агаарын хөлөг ашиглах; болон

(4) агаарын хөлөг нь хэрэглэлийн тусламжтайгаар ойртолт үйлдэн буух аэродром руу нисэх хангалттай түлштэй байх.

(d) Агаарын хөлгийн дарга нь энэ дүрмийн (c)-г үл харгалзан нэг хөдөлгүүртэй агаарын хөлгөөр сэмжин үүлнээс дээш өндөрт ИХНД-ээр зорчигч тээврийн нислэг үйлдэж болохгүй.

135.157 ХНД-ээр нислэг үйлдэх цаг уурын нөхцөл

Нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь нисэн очихоор төлөвлөсөн аэродромд очих тооцоот цагт хүртэл цаг агаарын бодит мэдээ, эсхүл урьдчилсан ба бодит цаг уурын мэдээнд заагдсан цаг агаарын нөхцөл нь тухайн нисэн очих аэродромын AIP-д заасан минимум хязгаарлалтаас их байвал ХНД-ээр нислэг үйлдэж болохгүй.

135.159 Аэродромын минимум - ХНД-ээр үйлдэх нислэг

(a) Агаарын хөлгийн дарга нь буултын ойртолтын төгсгөлийн цэг, эсхүл буултын ойртолтын төгсгөлийн үе шатыг(ойртолтын төгсгөлийн цэгийг заагдаагүйтохиолдолд)өнгөрөхөөс өмнө тухайн аэродромын орчны харагдац нь хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын хувьд тухайн аэродромын AIP-д заасан орчны харагдацаас доогуур байгааг тухайн үеийн цаг уурын мэдээнд заасан бол хэрэглэлтийн тусламжтайгаар буултын ойртолтыг үргэлжлүүлж болохгүй.

(b) Энэ зүйлийн (a) заалтын хувьд буултын ойртолтын төгсгөлийн үе шат нь:

(1) буултын ойртолтын төгсгөлийн цэгээс эсхүл хэрэглэлийн тусламжтайгаар буултын ойртолт үйлдэх журамд заагдсан байгууламжаас;эсхүл

(2)хэрэв буултын ойртолтын төгсгөлийн цэгийг тусгайлан заагдаагүй тохиолдолд онгоц, буулт үйлдэх журамд заасан зайд эргэлтийг бүрэн гүйцэтгэн буултын чиглэлд орох цэгээс тус тус эхэлнэ.

135.161.ХНД-ээр хөөрөлт үйлдэх хязгаарлалтууд

(a) Цаг уурын нөхцөл нь ИНД91.413-д заасан хөөрөлтийн минимумд, эсхүл түнээс дээгүүр болон ИНД91.413-д заасан ХНД-ээр буулт үйлдэх зөвшөөрөгдсөн минимумаас доогуур бол дараах тохиолдолд тухайн аэродромоос ХНД-ээр хөөрөлт үйлдэхгүй:

(1) хоёр хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд, агаар тогтуун байх үед нэг хөдөлгүүр татгалзсан үеийн чиг шулуун нислэгийн хурдтайгаар, хөөрөлт үйлдсэн аэродромоос нислэгийн нэг цагаас дээш хугацаагаар нисэх бол; эсхүл

(2) гурав, эсхүл түүнээс олон хөдөлгүүртэй агаарын хөлгийн хувьд, агаар тогтуун байх үед нэг хөдөлгүүр татгалзсан үеийн чиг шулуун нислэгийн хурдтайгаар, хөөрөлт үйлдсэн аэродромоос нислэгийн хоёр цагаас дээш хугацаагаар нисэх бол.

135.163. Багасгасан горимоор хөөрөлт үйлдэх минимум

(a) Гэрчилгээ эзэмшигч нь ИНД 91.413 (g)-д шаардсан багасгасан горимоор хөөрөлт үйлдэх журмыг өөрийн нислэгийн заавартаа тусгасан тохиолдолд хөөрөлтийн минимумаас бага горимоор хөөрөлтийг гүйцэтгэж болно.

(b) Багасгасан горимоор хөөрөлт үйлдэх журамд дараах зүйлийг бататгасан байна:

(1) нисэх багийн бүх гишүүд нь багасгасан горимоор хөөрөлт үйлдэхэд бэлтгэгдэж мэргэшсэнийг; болон

(2) ашигладаг хөөрөх буух зурвас нь тэнхлэгийн голчийн тэмдэглэгээтэй, эсхүл тэнхлэгийн гол шугам нь гэрэлтдэг байх; болон

(3) ашигладаг хөөрөх буух зурвас нь багасгасан горимоор хөөрөлт үйлдэх минимум нь тухайн аэродромын AIP-ийн дагуу зөвшөөрөгдсөн хэмжээнд байх; болон

(4) агаарын хөлөг нь сэнст хоёр хөдөлгүүртэй бол автомат флюгер, эсхүл сэнсний өнцгийг автоматаар өөрчлөх системээр тоноглогдсон гэдгийг; болон

(5) хөөрөх буух зурвасны харагдац нь тухайн зурвасны дагуух алсын барааны харагдац /RVR/ - аар тогтоогдсон байх; болон

(6) хөөрөлт үйлдэхэд шаардлагатай харагдацыг тодорхойлох, хянах аргачлал нь ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөгдсөн гэдгийг.

135.165 ХНД-ээр нислэг үйлдэх

(a) Агаарын хөлгийн дарга нь, дор дурдсанаас бусад тохиолдолд агаарын тээврийн нислэгийг AIP-д заасан хязгаарлалтын хүрээнд ХНД-ээр маршрутын нислэг гүйцэтгэнэ:

(1) бодит аюулаас зайлсхийх зайлшгүй шаардлага тулгарсан үед, эсхүл

(2) НХУ-ний радиолокаторын хяналтан дор нислэг үйлдэх үед, эсхүл

(3) НХУ-ний нэгжийн зөвшөөрлийн дагуу маршрутын бус нислэг үйлдэж байгаа үед, эсхүл

(4) гэрчилгээ эзэмшигчийн батлагдсан нислэгийн зааварт өөрөөр тодорхойлогдсон бол.

(b) Холбогдох НХУ-ний нэгжээс хяналттай агаарын зайд нислэг үйлдэх зөвшөөрөл олгогдоогүй бол агаарын хөлгийн дарга нь тухайн аэродромын хувьд AIP-д заасны дагуу ХНД-ээр хөөрөлт болон буултын ойртолт үйлдэх журмуудыг дагаж мөрдөнө.

(с) Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга нь тухайн аэродромын хувьд AIP-д заасны дагуу ХНД-ээр хөөрөлт болон буултын ойртолт үйлдэх журмуудыг дагаж мөрдөнө.

D БҮЛЭГ. НИСЛЭГ, ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

135.201. Зорилго

(а) Энэ зүйлийн (b),(c) ба (d)-д зааснаас бусад тохиолдолд, нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа онгоцны нислэг, техникийн үзүүлэлтэд тавигдах хязгаарлалтууд энэ бүлэгт тусгагдсан болно.

(b) ИНД 135.229-135.235-р зүйл нь дараах нөхцөлөөр гэрчилгээжсэн сэнст онгоцонд хамаарахгүй:

(1) АНУ-ын иргэний нисэхийн стандарт FAR 23-ын хэвийн ангилал, эсхүл түүнтэй адил төстэй НТЧ-ын стандартууд; эсхүл

(2) АНУ-ын иргэний нисэхийн стандарт SFAR 23-ын НТЧ-ын стандартууд, эсхүл түүнтэй адил төстэй стандартууд.

(с) Энэ дүрмийн ИНД 135.209, 135.213, 135.223 болон 135.225-р зүйлийн заалтууд нь дараах нөхцөлөөр гэрчилгээжсэн сэнст онгоцонд хамаарахгүй:

(1) АНУ-ын иргэний нисэхийн стандарт SFAR 41-ийн стандартууд, эсхүл түүнтэй адил төстэй НТЧ-ын стандартууд; эсхүл

(2) АНУ-ын иргэний нисэхийн стандарт FAR 23-ын зорчигчтээврийн (**commuter**) ангиллын НТЧ-ын стандартууд; эсхүл

(3) энэ дүрмийн Хавсралт А-д заагдсан НТЧ-ын стандартууд.

(d) Энэ бүлгийн шаардлагуудыг бүрэн хангахгүй онгоцыг ашиглалтын хязгаарлалтын нэмэлт үзүүлэлтийн дагуу нислэг үйлдэхийг зөвшөөрч болно.

135.203. Нөөц

135.205. ИНД 121 Бүлэг D-н шаардлагуудад нийцэх

(а) Гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоц нь АНУ-ын иргэний нисэхийн стандарт FAR Part 25-ын НТЧ-ын стандарт, эсхүл түүнтэй адил чанарын НТЧ-ын стандартын дагуу гэрчилгээжсэн бол ИНД 121 Бүлэг D-д заасан нислэгийн үзүүлэлт, ашиглалтын хязгаарлалтуудыг дагаж мөрдөнө.

135.155 Онгоцны ерөнхий үзүүлэлт

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоцны хувьд дараах зүйлийг бататгана:

(1) хөөрөхийн өмнөх хөөрөлтийн жин нь тухайн нислэгийн хувьд, энэ бүлгийн дагуу зөвшөөрөгдсөн жингээс илүүгүйг; болон

(2) энэ бүлэгт заасан нислэг техникийн үзүүлэлтүүдийн шаардлагуудыг хангаж буйг тодорхойлоход ашиглагдах өгөгдөхүүнүүд нь:

(i) тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тусгагдсан байх; эсхүл

(2) бохирдсон (**contaminated**) – хөөрөх буух зурвасны буултын зайн өгөгдөхүүнүүдийн хувьд тухайн онгоцыг үйлдвэрлэгчээс тогтоогдсон ба ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрснийг.

135.209 Хөөрөлтийн зай

(a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоцны хувьд дараах зүйлийг бататгана:

(1) тухайн онгоцны хөөрөлтийн үеийн жин нь нислэгийн ашиглалтын зааварт заасан хөөрөлтийн хамгийн их жингээс хэтрүүлэхгүйг; болон

(2) хөөрөлт үйлдэхэд шаардлагатай зай нь хөөрөлтийн гүйлтийн боломжит зайн 85 %-иас хэтэрч болохгүйг; болон

(b) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-д заасны дагуу хөөрөлтийн жин болон хөөрөлтийн зайг тодорхойлохдоо дараах зүйлүүдийг харгалзана:

(1) хөөрөлтийн гүйлтийн боломжит зай; болон

(2) хөөрөлт үйлдэхээс өмнөх онгоцны хөөрөлтийн жин; болон

(3) хөөрөлт үйлдэх аэродромын өндөр /даралтаар/; болон

(4) аэродром орчмын гадна агаарын хэм; болон

(5) ХБЗ-ны төрөл болон нислэг хийх үеийн нөхцөл; болон

(6) хөөрөх чиглэлд дэх ХБЗ-ны налуу; болон

(7) эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины вектор 150%-иас багагүй байх.

135.211 ХБЗ-ны гадаргуу болон налууг тооцоолох хүчин зүйл

(a) Гэрчилгээ эзэмшигч нь онгоцны үзүүлэлтийн өгөгдөхүүнийг өөр хэлбэрээр зөвшөөрөх боломжгүй бол ХБЗ-ны гадаргуугийн төрлөөс хамаарч ИНД 135.209

(b) (5), эсхүл ИНД 135.229 (c) (4)-ийн дагуу тооцоолсон хөөрөлтийн зай, ИНД 135.223(c) (3) ба ИНД 135.229 (c) (4)-ийн дагуу тооцоолсон буултын зайг дараах байдлаар засварлан тооцно:

(1) ХБЗ-ны өөр төрлийн гадаргуугийн хувьд Хүснэгт 1-д үзүүлсэн хүчин зүйлээр засвар хийнэ; болон

(2) ХБЗ-ны налууугийн хувьд дараах байдлаар тооцон өөрчлөлт хийнэ:

(i) өгсүүр налууг 3% хүртэл тооцоходоо 1% тутамд хөөрөлтийн зайг 5%-иар ихэсгэнэ;эсхүл

(ii) өгсүүр налууг 3% хүртэл тооцоходоо 1% тутамд буултын зайг 5%-иар багасгана;эсхүл

(iii) газрын уруу налууг 3% хүртэл тооцоходоо 1% тутамд хөөрөлтийн зайг 5%-иар багасгана;эсхүл

(iv) газрын уруу налууг 3% хүртэл тооцоходоо 1% тутамд буултын зайг 5%-иар ихэсгэнэ.

Хүснэгт 1.

<i>Гадаргуугийн төрөл</i>	<i>Хөөрөлтийн зай</i>	<i>Хөөрөлтийг зогсоох зай</i>	<i>Буултын зай</i>
<i>Засмал</i>	x 1.00	x 1.00	x 1.00
<i>Чулуун /Coral шүрэн/</i>	x 1.00	x 1.03	x 1.05
<i>Төмөр</i>	x 1.05	x 1.06	x 1.08
<i>Засагдсан хөрс</i>	x 1.08	x 1.14	x 1.16
<i>Засагдаагүй хөрс</i>	x 1.14	x 1.20	x 1.18

135.213Хөөрөлт, гаралтын бүдүүвч – ХНД-ээр нислэг үйлдэх

(a) Гэрчилгээ эзэмшигч нь хоёр эсхүл түүнээс олон хөдөлгүүртэй онгоцоор ХНД-ийн дагуу нислэг үйлдэх тохиолдолд онгоцны эрсдэлтэй хөдөлгүүр татгалзах магадлалтай гэж тооцон хөөрөлт үйлдэх зурвасны дагуу 15м /50 feet/-ээс дээш өндөрт аливаа саад байхгүйг бататгана.

(b) Хөөрөлт үйлдэх зурвасны хажуугаас саад хүртэлх зай дараах хэмжээнээс бага тохиолдолд аливаа саадыг хөөрөлт үйлдэх зурвасанд байна гэж тооцно:

(1) хөөрөлтийн үед нислэгийн чиглэлийг 15 градусаас ихээр өөрчлөхгүй:

(i) хөөрөлт үйлдэн өндөр авах хөндлөн чиглэлд саад хүртэл 45м+0.10D зайд буюу600м хүртэл, эсхүл онгоцны ил харааны эсхүл радио навигацийн төхөөрөмжийг ашигланнисэж байгаа бол 300м хүртэл; болон

(ii) өдрийн цагт VMC-ээр үйлдэх нислэгийн хувьд хөөрөлт үйлдэн өндөр авах үед хөндлөн чиглэлд саад хүртэл 30м+0.10D зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радионавигацийн төхөөрөмжийг ашиглан нисэж байгаа бол 300м хүртэл.

(2) хөөрөлтийн үед чиглэлийг 15 градусаас их хэмжээгээр өөрчлөх шаардлагатай үед:

(i) хөөрөлт үйлдэн өндөр авах хөндлөн чиглэлд саад хүртэл $45\text{м}+0.10D$ зайд буюу 900м хүртэл, эсхүл онгоцны ил харааны эсхүл радио навигацийн төхөөрөмжийг ашиглан нисэж байгаа бол 300м хүртэл; болон

(ii) өдрийн цагт VMC-ээр үйлдэх нислэгийн хувьд хөөрөлт үйлдэн өндөр авах үед хөндлөн чиглэлд саад хүртэл $30\text{м}+0.10D$ зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радионавигацийн төхөөрөмжийг ашиглан нисэж байгаа бол 300м хүртэл.

(c) Энэ зүйлийн (b)-д заасан D нь хөөрөлтийн боломжит зайн төгсгөл буюу хэвтээ чиглэлд онгоц хөөрөх цэгээс саад хүртэлх хэмжээ.

(d) Гэрчилгээ эзэмшигч ньэнэ зүйлийн (a)-д заасны дагуу хөөрөлт гаралтын бүдүүвчийг тооцохдоо дараах зүйлүүдийг харгалзана:

(1) дараах хүчин зүйлүүдийг тооцсон байна:

(i) хөөрөлт гүйлт үйлдэхээс өмнөх онгоцны хөөрөлтийн жин; болон

(ii) хөөрөлт үйлдэх аэродромын өндөр; болон

(iii) атмосферын даралт олон улсын стандарт атмосферээс 1%-иас илүү өөрчлөгдөж буй тохиолдолд аэродромын даралтаар тооцоологдох өндөр; болон

(iv) аэродром орчмын агаарын температур; болон

(v) Эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины векторын 150%-иас багагүй байх.

(2) хөөрөлтийн гадаргуугаас дээш 15м /50 feet/-ийн өндөрт хүрэхээс өмнө нислэгийн чиглэлийг өөрчлөхгүй.

(3) ИНЕГ-аас зөвшөөрөөгүй бол:

(i) хөөрөлтийн гадаргуугаас дээш 15м /50 feet/-ийн өндөрт хүрэхээс өмнө кренийг 15 градусаас хэтрүүлэхгүй; болон

(ii) хөөрөлтийн гадаргуугаас дээш 120м /400 feet/ хүртэлх өндөрт крен хийх өнцгийг 20 градусаас хэтрүүлэхгүй; болон

(iii) хөөрөлтийн гадаргуугаас дээш 120м /400фут/- ээс дээш өндөрт кренийг 25 градусаас хэтрүүлэхгүй.

(4) зөвшөөрлийг дараах зүйлүүдийг үндэслэн олгоно:

- (i) нислэгийн зам ба хурдад крений үзүүлэх нөлөө;болон
- (ii) нислэгийн хурдыг ихэсгэснээс үүсэх зайн өөрчлөлт;болон
- (iii) энэ дүрмийн ИНД 135.215-ын дагуу хийгдэх өндөр авалтын градиентийн алдагдал ба онгоцны уналтын хязгаарын хадгалалт.

135.215 Хөдөлгүүрийн татгалзал- градиент ба онгоцны уналтыг засах/stall correction/

(a) Гэрчилгээ эзэмшигч нь онгоцны үзүүлэлтийн өгөгдөхүүнд хангалтгүй тохиолдолд энэ дүрмийнИНД 135.213(d)(4)(iii)-г дагаж мөрдөх үүднээс өндөр авалтын градиентын алдагдлыг Хүснэгт 2-т заасан үзүүлэлтээр тооцоолж хурдны уналтаас болж онгоц унах хязгаарыг хадгална.

Хүснэгт 2

Эргэлт /bank/-ийн өнцөг	Хурдны өөрчлөлт	Градиентын өөрчлөлт
15°-19°	V2	1х Онгоцны Нислэг ашиглалтын заавар 15° градиент алдагдал
20°-24°	V2+15 knots	2х Онгоцны Нислэг ашиглалтын заавар 15° градиент алдагдал
25°	V2+19 knots	3х Онгоцны Нислэг ашиглалтын заавар 15° градиент алдагдал

135.217 Чиг шулуун нислэгийн үед хөдөлгүүр (critical engine) татгалзах

(a) Гэрчилгээ эзэмшигч нь хоёр, эсхүл түүнээс олон хөдөлгүүртэй онгоц бүрийн хувьд, тухайн онгоц нь аюулгүй хамгийн нам өндөр ба түүнээс дээш өндөр дахь эерэг налуу /positive slope/-д дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд нислэг гүйцэтгэх шаардлага хангагдсан аэродромоос дээш 300м /1000 feet/-ийн өндөрт нислэгийг үргэлжлүүлэх боломжтой эсэхийг бататгана:

- (1) урьдчилсан таамагласан цаг агаарын нөхцөл байдлууд тухайн нислэгттооцоологдсон;болон
- (2) хөдөлгүүр татгалзсан; болон
- (3) ажиллагаатай үлдсэн хөдөлгүүрүүд нь хамгийн их чадлын горимоор ажиллаж байгаа.

(b)чиг шулуун нислэгийнхязгаарлалтуудыг энэ зүйлийн (a)-гийн дагуу тооцолохдоо гэрчилгээ эзэмшигч дараах зүйлийг бататгана:

(1) бүх хөдөлгүүрүүд нь тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тодорхойлсон хамгийн их чадлын горимоор ажиллаж байгаа үед өндөр авалтын хурд нь 1 минутанд 90м /300 feet/-ээс багагүй байх өндрөөс дээш өндөрт тухайн онгоцыг ниснэ гэж тооцохгүй; болон

(2) нэг хөдөлгүүр татагалзсан гэж үзэх чиг шулуун нислэгийн градиент нь gross-gradient-minus 0.5% байхыг.

135.219Чиг шулуун нислэгийн 90 минутын хязгаарлалт

(a) Гэрчилгээ эзэмшигч нь хоёр хөдөлгүүрт онгоцоор, тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсанүзүүлэлтүүд болон тооцоот буултын жинд нийцсэн аэродромоос 90 минутаас дээшгүй зайд нислэг үйлдэнэ.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь гурав болон түүнээс дээш хөдөлгүүртэй онгоцоор, тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан үзүүлэлтүүд болон тооцоот буултын жинд нийцсэн аэродромоос 90 минутаас дээшгүй зайд нислэг үйлдэнэ.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд гурав болон түүнээс дээш хөдөлгүүртэй онгоцоор, тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан үзүүлэлтүүд болон тооцоот буултын жинд нийцсэн аэродромоос 90 минут дээш зайд нислэг үйлдэж болно:

(1) нислэгт хоёр хөдөлгүүр татгалзах үеийн нислэгийн замын өгөгдөхүүнүүд нь тухайн онгоц, тооцоолсон цаг агаарын нөхцөл байдалд хоёр хөдөлгүүр нэгэн зэрэг татгалзах цэгээс татгалзсан хоёр хөдөлгүүртэйгээр буулт үйлдэх журмыг мөрдөн буулт үйлдэх аэродром хүртэл нислэгээ үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлсэн;болон

(2) хэрэв нислэгийн чиглэл дэх цаг агаарын нөхцөл байдал нь мөстөлтөөс хамгаалах системийн ажиллагааг шаардаж байгаа бол:

(i) нислэгийн чиглэл дэх хамгийн бага аюулгүй өндөрт эерэг налуу (positive slope)-тай; эсхүл

(ii) градиент нь gross-gradient-minus 0.5% байх үеийн болон нислэгийн чиглэл дэх хамгийн эрсдэлтэй хэсэгт хоёр хөдөлгүүр татгалзсан гэж үзэн энэ зүйлийн (d)-д зааснаас бусад тохиолдолд,

нислэгийн маршрутын дагуу 18.6км (10nm)-ийн доторх бүх саад ба уулархаг бүсээс 600м (2000 feet)-ийн босоо зайд аливаа саадгүй.

(3) хоёр хөдөлгүүр татгалзсаны дараа буулт үйлдэх аэродромын дээр 450м/1500feet/ -ийн өндөрт нислэгийн зам нь эерэг налуу (positive slope)-тай,

(4) хоёр хөдөлгүүр татгалзсан гэж тооцож буй цэг дэх онгоцны жин нь, буулт үйлдэхээр төлөвлөж буй аэродромд хүрэх хангалттай түлштэй ба тухайн аэродромын дээр наад зах нь 450м/1500feet/-ийн өндөрт нисэн ирэх ба нисэн ирсний дараа 15 минутын турш нислэг үйлдэх боломжтой жингээс багагүй.

(d) Хэрэв нисгэгч радио навигацийн хэрэглэл ашиглах боломжтой бол чиглэлийг 9.3км /5nm/ хязгаарт хадагалах ба энэ зүйлийн (c)(2)(ii)-т заасан 18.6км / 10nm/зайг 9.3км /5nm/ хүртэл багасгаж болно.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (c)-гийн шаардлагад нийцүүлэн тооцоо хийхдээ, цаг агаар тогтуун үед, агаарын стандарт хэмд, хөдөлгүүрийн чадал нь чиг шулуун нислэгийн хурдтай байх үед нислэгийн замын дагуу буулт үйлдэж болох аэродромоос 90 минутаас дээш зайд, нислэгийн маршрутын хамгийн эрсдэлтэй цэгт онгоцны 2 хөдөлгүүр татгалзсанд тооцож бодно.

135.221 Буултын өндөр авалт- нисэн очих болон нөөц аэродром

(a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоцны хувьд дараах шаардлагыг хангасан байна.

(1) Тооцоот цагт нисэн очих аэродром болон нөөц аэродромдбуулт үйлдэх үеийн гадна агаарын хэм, аэродромын өндрийг тооцсон онгоцны буултын жин нь ойртолт ба буултын үед өндөр авах хамгийн их жингээс илүүгүй байна;болон

(2) 60м /200feet/-ээс доош шийдвэр гаргах өндөртэйгээр, хэрэглэлийн тусламжтайгаар ойртолт үйлдэх үед эрсдэлтэй хөдөлгүүр /critical engine/ татгалзсан гэж үзэн хоёрдугаар тойрогт гарах үед нислэгт зарцуулагдах түлшийг тооцсон байх ба тухайн онгоцны ойртолтын болон хөөрөлтийн хүнд нь өндөр авах дараах градиентэд тохирч байна:

(i) 2.5%-иас доошгүй, эсхүл

(ii) ИНД 135.213-ын дагуу ойртолтоос хоёрдугаар тойрогт гарах нислэгийн зам дахь аливаа саадыг тойрч гарах шаардлагатай өндөр авалтын градиент.

135.223 Буултын зай- хуурай зурвас

(a) Гэрчилгээ эзэмшигч нь ашиглаж буй онгоцныхоо төлөвлөсөн цагт буух үеийн буултын жинг тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт заасан буултын жингээс хэтрүүлж болохгүй.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь төлөвлөсөн цагт нисэн очих болон нөөц аэродромд буулт үйлдэх үеийн онгоцны буултын жинг тооцоолохдоо, зурвасны босгоноос дээш 15м /50feet/ өндөрт байрлах цэгээс буулт үйлдэх боломжит нийт зайн 85% дотор онгоц бүрэн зогсоно гэж үзнэ.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь буултын жинг энэ зүйлийн (b)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг тооцсон байна:

(1) аэродромын өндөр; болон

(2) тухайн аэродромын гадна агаарын хэм; болон

(3) ХБЗ-ны гадаргуугийн төрөл, нөхцөл байдал;болон

(4) тухайн ХБЗ-ны буулт үйлдэх чиглэл дэх налуу;болон

(5) эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины векторын 150%-иас багагүй байх.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b),(c)-д заасны дагуу буулт үйлдэх онгоцыг нислэгт гаргахдаа, дараах зүйлийг харгалзсаны үндсэн дээр боломжит ХБЗ-д буулт үйлдэнэ гэж тооцоолно:

(1) цаг агаарын урьдчилсан байдал; болон

(2) хүрээлэн байгаа газар нутаг;болон

(3) ойртолт, буултын аэродромын тоноглолууд; болон

(4) ойртолтоос хоёрдугаар тойрогт гарах нислэгийн зам дахь саадууд.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь нисэн очихаэродромын хувьд энэ зүйлийн (d) заалтыг мөрдөх боломжгүй тохиолдолд нөөц аэродром нь энэ зүйлийн (a), (b) ба (c)-д нийцэж байвал онгоцыг нислэгт гаргаж болно.

135.223 Буултын зай- нойтон ба бохирдсон зурвас

(a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэг үйлдэж байгаа онгоц бүрийн хувьд дараах зүйлийг бататгана:

(1) цаг агаарын тухайн үеийн мэдээ, эсхүл урьдчилсан мэдээнд, эсхүл энэ мэдээнүүдийн нийлбэр ньонгоц нисэн очих үед ХБЗ нойтон байх магадлалтай гэж заасан бол, буултын боломжит зай ИНД 135.223-д шаардсан буултын зайны 115%-иас багагүй байхыг; болон

(2) цаг агаарын тухайн үеийн мэдээ, эсхүл урьдчилсан мэдээнд, онгоц нисэн очих үед ХБЗ бохирдсон байх магадлалтай гэж заасан бол, буултын боломжит зай нь:

(i) энэ хэсгийн (a)(1)-д шаардсан буултын зайнаас багагүй байхыг, эсхүл

(ii) буултын зай нь бохирдсон зурваст буух зайн өгөгдөхүүнүүдээр тодорхойлогдсон байхыг.

(b) Өгөгдөхүүнүүд нь нойтон зурвас дээрх буултын зайг богинохон тодорхойлж болох ба энэ тохиолдолд нойтон зурвас дээрх буултын зай нь энэ зүйлийн (a) (1)-д зааснаас богино зайд байна.

135.227 Огцом ойртолт ба богино зайд буулт үйлдэх арга

(a) Гэрчилгээ эзэмшигч нь дараах нөхцөлд ойртолтын үед өндөр алдах хазайлтын 4.5° болон түүнээс илүү өнцгийг ашиглан, 10.5-15м /35-50feet/-ийн хоорондох тэгшлэх өндөр (screen height)-т огцом ойртолтын журам/steep approach procedures/-ыг гүйцэтгэж болно:

(1) огцом ойртолтын үе дэх онцгой нөхцөл байдлыг багтаасан журмууд, бусад хязгаарлалтууд, ойртолтын зөвшөөрөгдсөн хамгийн их хазайлтын өнцөг зэрэг огцом ойртолтын журмыг ашиглах үеийн талбайн уртын өөрчлөлтүүд нь тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан; болон

(2) ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд, ил харааны ойртолтын хазайлтыг дохиолох системийг багтаасан ойртолтын үеийн хазайлтыг заагч систем нь (approach slope indicator system) огцом ойртолт үйлдэх аэродромын хувьд боломжтойүед;болон

(3) ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд цаг агаарын хязгаарлалт (weather minima) огцом ойртолт үйлдэх ХБЗ бүрд тодорхойлогдож, зөвшөөрөгдсөн; болон

(4) ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд дараах зүйлийг тооцсон байна:

(i) саадууд;болон

(ii) буух ойртолтын глиссадын дохиоллын маягт болон ил харааны туслах төхөөрөмж, микродолгионы буултын систем (MLS), сансрын навигацийн байрлал тодорхойлолх систем (GPS), хэрэглэлээр буулт үйлдэх систем (ILS), курсын радиомарк (LOC), хэт өндөр давтамжийн олон чиглэлт дамжуулагч станц (VOR), чиглүүлэх радио нэвтрүүлэгч (NDB), ХБЗ-ны заавар; болон

(iii) шийдвэр гаргах харьцангуй өндөр ба шийдвэр гаргах хамгийн бага өндөрт шаардагдах ил харах хэрэгсэлээр тоноглогдсон; болон

(iv) онгоцны бүхээгт хэрэглэгдэх тоноглол; болон

(v) нисэгчийн бэлтгэл ба тухайн аэродромын талаарх мэдлэгхангагдсан; болон

(vi) тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан хязгаарлалт ба журмууд; болон

(vii) ойртолтоос хоёрдугаар тойрогт гарах нөхцөлүүд.

135.228 FAR Part 23 commuter category ба SFAR41

(a) Энэ дүрмийн ИНД 135.229 ба 135.235-р зүйлүүд нь үйл ажиллагаандаа АНУ-ын иргэний нисэхийн стандарт FAR Part 23 commuter category SFAR41 стандартыг хангасан онгоцыг нислэгийн үйл ажиллагаандаа ашигладаг гэрчилгээ эзэмшигчийн хувьд хүчин төгөлдөр байна.

135.229 Хөөрөлтийн зай

(a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглах онцгой хөөрөлтийн жинг тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан хөөрөлтийн хамгийн их жингээс хэтрүүлж болохгүй.

(b) Энэ зүйлийн (a)-гийн шаардлагыг хангах үүднээс гэрчилгээ эзэмшигч нь эрсдэлтэй хөдөлгүүр Vef хурдны үед татгалзсан гэж үзэн V1 хурдыг ашиглан хөөрөлтийн хамгийн их жинг тооцоолохдоо дараах зүйлүүдийг бататгана:

(1) хөөрөлтийг зогсооход шаардагдах зай нь хөөрөлтийг бүрэн зогсоох боломжит зайнаас ихгүйг; болон

(2) хөөрөлт үйлдэхэд шаардагдах зай нь хөөрөлтийн боломжит зайнаас ихгүйг; болон

(3) хөөрөлтийн боломжит зайн саадгүй байх аливаа хэсэг нь хөөрөлт үйлдэх гүйлтийн боломжит зайн хагасаас ихгүйг;

(4) хөөрөлт үйлдэх гүйлтийн шаардлагатай зай нь хөөрөлтийг зогсоох ба үргэлжлүүлэх, шийдвэр гаргах V1 хурдыг ашиглан тооцсон хөөрөлт үйлдэх гүйлтийн боломжит зайнаас ихгүйг.

(с) гэрчилгээ эзэмшигч нь хөөрөлтийн хамгийн их жинг энэ зүйлийн (b)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг бататгана:

(1) аэродромын өндөр(aerodrome elevation);болон

(2) агаарын даралт нь стандарт агаарын даралтаас 1%-иас дээш өөрчлөлттэй тохиолдолд тухайн аэродромын даралтын өндөр; болон

(3) тухайн аэродром орчмын гадна агаарын хэм;болон

(4) тухайн ХБЗ-ны гадаргуугийн төрөл ба нөхцөл байдал;болон

(5) хөөрөлтийн чиглэл дэх ХБЗ-ны налуу; болон

(6) цаг уурын мэдээнд өгөгдсөн эсэргүүцэх салхины 50%-иас ихгүй, эсхүл арын салхины векторын 150%-иас багагүй байна.

135.231 Хөөрөлтийн үеийн нислэгийн зувас ба гаралт

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоц бүрийн хувьд хөөрөх үед эрсдэлтэй хөдөлгүүр татгалзсан гэж үзэхэд хөөрөлт үйлдэх нислэгийн зурвасны дагуу босоо зайд аливаа саадгүйг бататгана:

(1) онгоц хөөрөлтөнд 15°-аас ихгүй өнцгөөр эргэлт /bank/хийхээр бол 10.5 метр /35feet/-ээс дээш өндөрт;болон

(2) онгоц хөөрөлтөнд 15°-аас их өнцгөөр эргэлт /bank/ хийхээр бол 15 метр /50feet/-ээс дээш өндөртхийнэ гэдгийг.

(b) Энэ зүйлийн (а)-д заасны дагуу нислэг гүйцэтгэх үед нислэгийн замын хажуугаас аливаа саад хүртэлх зай нь дараах зайнаас бага бол тухайн саадыг хөөрөлтийн зурвасанд байна гэж үзнэ:

(1) нислэгийн чиглэлийг 15°-аас ихээр өөрчлөх шаардлагагүй тохиолдолд:

(i) хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд хөндлөн саад хүртэл 45м+0.10D зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн хэрэглэл ашиглан нислэгийг гүйцэтгэж байгаа бол 300м хүртэл

(ii) өдрийн цагт VMC /ил хараагаар нислэг үйлдэх цаг агаарын нөхцөл/-гээр үйлдэх нислэгийн хувьд хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд хөндлөн саад хүртэл $30\text{м}+0.10D$ зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацгийн хэрэглэл ашиглан нислэгийг гүйцэтгэж байгаа бол 300 м хүртэл.

(2) нислэгийн чиглэлийг 15° -аас ихээр өөрчлөх шаардлагатай тохиолдолд:

(i) хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд хөндлөн саад хүртэл $45\text{м}+0.10D$ зайд буюу 900м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацгийн хэрэглэл ашиглан нислэгийг гүйцэтгэж байгаа бол 600м хүртэл

(ii) өдрийн цагт VMC-гээр үйлдэх нислэгийн хувьд хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд хөндлөн саад хүртэл $30\text{м}+0.10D$ зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио хэрэглэл ашиглан нислэгийг гүйцэтгэж байгаа бол 300м хүртэл.

(с) Гэрчилгээ эзэмшигч нь хөөрөлтийн үеийн нислэгийн замыг энэ зүйлийн (а)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг бататгана:

(1) дараах нөхцөл байдлыг харгалзана:

(i) хөөрөх гүйлт эхлүүлэхээс өмнөх үеийн хөөрөлтийн жин; болон

(ii) аэродромын өндөр (aerodrome elevation);болон

(iii) агаарын даралт нь стандарт даралтаас 1%-иас дээш өөрчлөлттэй үеийн аэродромын даралтын өндөр;болон

(iv) аэродром орчмын агаарын температур;болон

(v) цаг агаарын мэдээнд өгөгдсөн эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины 150%-иас багагүй байх.

(2) хөөрөлт үйлдэж байгаа зурваснаас дээш 15м /50feet/-ийн өндөрт хүртэл нислэгийн чиглэлийг өөрчлөхгүй байхыг; болон

(3) ИНЕГ-аас өөрөөр зөвшөөрөөгүй бол:

(i) хөөрөлт үйлдэж байгаа зурваснаасдээш 15м /50feet/-ийн өндөрт хүртэл 15° -аас их эргэлт үйлдэхгүйг;болон

(ii) хөөрөлт үйлдэж байгаа зурваснаас дээш 120м хүртэл /400feet/-ийн өндөрт хүртэл 20°-аас их эргэлт үйлдэхгүйг; болон

(iii) хөөрөлт үйлдэж байгаа зурваснаас дээш 120м /400feet/-ээс дээш өндөрт 25°-аас эргэлт үйлдэхгүйг.

(4) дараах зүйлүүдийг мөрдөхийг:

(i) эргэлт үйлдэх(bank angle) нь нислэгийн чиглэл болон нислэгийн хурдад нөлөөлөхийг; болон

(ii) нислэгийн хурдыг ихэсгэснээс зай нэмэгдэхийг; болон

(iii) өндөр авалтын градиентын алдагдал болон хурдны уналт (stall)-ын хязгаарыг барихыг.

135.235 Буултын зай- хуурай зурвас

(a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгт ашиглагдаж буй онгоц бүрийн хувьд, төлөвлөсөн цагт буух үеийн онгоцны буултын жинг тухайн онгоцнуудын Нислэг ашиглалтын зааварт заасан буултын жингээс хэтрүүлж болохгүй.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь ашиглаж буй онгоц бүрийн хувьд, төлөвлөсөн цагт нисэн очих аэродром болон аливаа нөөц аэродромд буулт үйлдэх онгоцны буултын жин нь зурвасны босгоноос дээш 15м /50feet/-т байрлах цэгээс буулт үйлдэх боломжит зай (LDA)-н 70% дотор онгоц бүрэн зогсоно гэж тооцоолсон байна.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь буултын жинг энэ зүйлийн (b)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг харгалзана:

(1) аэродромын өндөр; болон

(2) тухайн аэродром дахь гадна агаарын хэм; болон

(3) ХБЗ-ны гадаргуун төрөл, нөхцөл байдал; болон

(4) тухайн ХБЗ-ны буулт үйлдэх чиглэл дэх налууг; болон

(5) цаг агаарын мэдээнд өгөгдсөн эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины векторын 150%-иас багагүй байх.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b), (c)-д заасны дагуу буултын тооцоо хийх онгоцыг нислэгт гаргахдаа, тухайн онгоц дараах нөхцөлийг тооцсон хамгийн боломжтой ХБЗ-д буулт үйлдэнэ гэж үзнэ:

- (1) цаг агаарын урьдчилсан байдал; болон
- (2) хүрээлэн байгаа газар нутаг; болон
- (3) ойртолт, буултын навигацийн тоноглолууд; болон
- (4) ойртолтоос хоёрдугаар тойрогт гарах нислэгийн зам дахь саадууд.

(е) Гэрчилгээ эзэмшигч нь нисэн очих аэродромын хувьд энэ зүйлийн (d)-д заасныг мөрдөх боломжгүй тохиолдолд, хэрэв нөөц аэродром нь энэ зүйлийн (a), (b) ба (c)-д нийцэж байгаа бол онгоцыг нислэгт гаргаж болно.

135.235 Буултын зай- нойтон ба бохирдсон зурвас

(а) Гэрчилгээ эзэмшигч нь цаг агаарын бодит, эсхүл урьдчилсан мэдээнд, онгоц нисэн очих үед ХБЗ нойтон, эсхүл бохирдсон байх магадлалтай гэж заасан бол нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоц бүрийн хувьд буултын боломжит зай 135.135-д шаардсан буултын зайн 115%-иас багагүй байна гэдгийн бататгана.

Е БҮЛЭГ. ЖИН БА ТӨВЛӨРӨЛТ

135.301 Зорилго

Энэ бүлгийн зорилго нь зорчигч, ачааг агаарын хөлгөөр тээвэрлэх үед жин ба төвлөрөлтийг тооцоолж хяналт тавих шаардлагууд болон тэдгээрийн зохицуулах журмыг тогтооход оршино.

135.303 Зорчигч, ачаа болон тээшний жин

(а) Гэрчилгээ эзэмшигч нь энэ бүлгийн (b), (c) болон (d)-д заасны дагуу гүйцэтгэж байгаа агаарын үйл ажиллагаа бүрт дараах зүйлүүдийн бодит жинг тогтоосон байна:

- (1) нийт зорчигчдын нийлбэр жин; болон
- (2) нисэх багийн гишүүдийн нийлбэр жин; болон
- (3) нийт гар тээш, ачааны нийлбэр жин.

(b) Зорчигчдын жинг (гар тээшийг оролцуулахгүйгээр) дараах зүйлүүдийн аль нэгээр тооцно:

(1) зорчигчдын бодит жингээр; эсхүл

(2) гэрчилгээ эзэмшигчийн зааварт тусгагдсан стандарт жингээр; эсхүл

(3) зорчигчдын зарлагдсан жин тус бүр дээр 4 кг нэмж.

(c) Нисэх багийн гишүүдийн жинг (гар тээшийг оролцуулахгүйгээр) дараах зүйлүүдийн аль нэгээр тооцно:

(1) нисэх багийн гишүүдийн бодит жингээр; эсхүл

(2) гэрчилгээ эзэмшигчийн зааварт тусгагдсан стандарт жингээр.

(d) Ачаа болон тээшний жинг дараах зүйлүүдийн аль нэгээр тооцно:

(1) ачаа болон тээшний бодит жингээр; эсхүл

(2) арилжааны агаарын тээврээр алслагдсан бүс нутгаас нислэг гүйцэтгэж байгаа үед ачаа болон тээшний жинг тогтоох боломжгүй тохиолдолд агаарын хөлгийн дарга гэрчилгээ эзэмшигчийн зааврын дагуу тогтоосноор.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)(2) эсхүл (c)(2)-д заасны дагуу стандарт жингээр тооцож байгаа үед стандарт жинг тооцох ИНЕГ-ын даргаас хүлээн зөвшөөрөгдсөн хяналтын хөтөлбөртэй байна.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь зорчигчдын зарлагдсан жинг (b)(3) эсхүл стандарт жинг (b)(2) эсхүл багийн гишүүдийн жинг (c)(2)-д заасны дагуу тооцож байгаа үед зорчигч болон багийн гишүүдийн бодит жин нь стандарт жингээс илүү тохиолодолд тухайн хүний бодит жинг ашиглаж байх талаар тусгасан ИНЕГ-ын даргаас хүлээн зөвшөөрөгдсөн журамтай байна.

(g) Гэрчилгээ эзэмшигчийн ажилтан нь энэ зүйлийн (b)(3)-н дагуу зорчигчдын зарлагдсан жинг тооцож байгаа үед тухайн зорчигчийн зарлагдсан жин нь бодит жингээс бага байгаад хянаана.

135.305 Агаарын хөлгийн ачааллын хязгаарлалтууд

(a) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлүүдийг бататгана:

(1) агаарын хөлгийн Нислэг ашиглалтын зааварт, эсхүл жин ба төвлөрөлттэй холбоотой бусад зөвшөөрөгдсөн бичиг баримтад заасан хязгаарлалтуудыг дагаж мөрдөхийг; болон

(2) агаарын хөлгийн түлшгүй үеийн, мөн хөөрөлт, буултын ба нислэгийн үеийн жинг зөвшөөрөгдсөн хамгийн их жингээс хэтрүүлэхгүйг; болон

(3) хөөрөлтийн өмнөх агаарын хөлгийн хүндийн төвийг энэ зүйлийн (a)(1)-д заагдсан хязгаарлалтанд байлгах ба эдгээр хязгаарлалтуудыг нислэгийн турш баримтална.

(b) Агаарын хөлгийн дарга нь нислэгийн өмнө ИНД 135.857 (b)(11) – (b)(15)-н дагуу шаардсан мэдээллүүдэд үнэлэлт өгч нислэгийн турш жин ба төвлөрөлт нь Нислэг ашиглалтын зааварт заасан хязгаарлалтуудын хүрээнд байхыг бататгана.

F БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛ БОЛОН ТОНОГЛОЛ

135.3513Орилго

Энэ бүлэг нь агаарын хөлгийн хэрэглэл болон тоноглолд тавигдах шаардлагуудыг тогтооно.

135.353Ерөнхий зүйл

(a) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагааг явуулж болохгүй:

(1) Агаарын хөлөг нь:

(i) энэ бүлэг болон ИНД 91-д шаардсан тухайн төрөл, маягийн хэрэглэл тоноглолуудтай байх;болон

(ii) холбоо болон навигацийн систем, тоноглолуудын тоо нь аливаа дутагдлын үед бие биенээ орлон найдвартай ажиллан, нислэгийн аюулгүй ажиллагааг тухайн нислэгийн аялалын турш хангадаг байх.

(2) агаарын хөлгийн холбоо болон навигацийн тоноглолуудын техникийн тодорхойлолт болон нислэг тэнцэх чадварын дараах шаардлагыг хангасан байна:

(i) энэ дүрмийн Хавсралт В; эсхүл

(ii) ИНД 125-ийн Хавсралт В; эсхүл

(iii) ИНД21-ийн Хавсралт С; эсхүл

(iv) ИНД26; эсхүл

(v) ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн нэмэлт тодорхойлолт болон стандартууд.

(3) агаарын хөлгийн холбоо болон навигацийн тоноглолууд нь тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн заавар болон ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн бусад заавар, зааварчилгын дагуу суурилагдсан байх; болон

(4) ИНД91.539-ийн дагуу батлагдсан MEL-д зааснаас бусад, тухайн агаарын хөлөгт суурилагдсан холбоо болон навигацийн тоноглолууд нь ажиллагаатай байх.

135.355 Суудлын даруулга

Гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоц бүрийн нисэх багийн гишүүдийн суудал нь мөрөвчит даруулга бүс эсхүл хөндлөн босоо даруулга бүсээртоноглогдсон байна.

135.357 Нэмэлт хэрэглэлүүд

Гэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлөг бүр дараах хэрэглэлүүдээр тоноглогдсон байна:

(1) ИНД21Хавсралт С (а)(1)(i)-д заасан НТЧ-ын загварын стандартын шаардлага хангасан хөдөлгүүрийн хэрэглэлүүд;болон

(2) сэнсний алганы өнцгийн өөрчлөлтөөр ухрах хүч өгөх сэнсний хувьд сэнс тулгуур дээр байх өнцөг /beta хязгаарт/, эсхүл эсрэг татах хүч үүсгэх өнцөг /reverse pitch/дээр байгааг заагч хэрэглэл буюу сэнсний алхам заагч.

135.359 Шөнийн нислэг

(а) Гэрчилгээ эзэмшигчийн шөнийн нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг нь дараах хэрэгсэлээр тоноглогдсон байна:

(1) буултын гэрэл;болон

(2) зорчигчдын тасалгааны гэрэл.

135.361Хэрэглэлийн нислэгийн дүрэм

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигчийн ХНД-ийн дагуу нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг нь дараах хэрэглэлээр тоноглогдсон байна:

(1) бие биенээсээ үл хамаарах ИНД 91 Бүлэг F-д заасан дараах нэмэлт хэрэглэл:

(i) чийг, эсхүл мөстөлтийн улмаас хэвийн үйл ажиллагаа нь алдагдахаас хамгаалагдсан,даралтын өөрчлөлтийг оруулж засвар хийх боломжтой км/ц (knot)-аар хэмжигдэх хурдны хэрэглэл; болон

(ii) өндрийг/даралтаар/ метр (feet)-ээр хэмжих хэрэглэл.

(2) нисгэгчийн бүхээг дэх хэрэглэлүүдийн гэрэлтүүлгэд зориулсан нөөц чийдэн;болон

(3) нөөц гал хамгаалагч.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)(1)(i)-ээс үл хамааран ИНД 91 Хавсралт F-д шаардсан хэрэглэлийг тусдаа тэжээлийн үүсгүүртэй нэмэлт авиагоризонт /attitude indicator/ суурилуулж болно.

135.363 Авран хамгаалах тоноглол

Гэрчилгээ эзэмшигчнь дараах зүйлийг бататгана:

(1) ИНД91.523(a) ба (b)-д заасныг үл харгалзангэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлөг бүрт ИНД 91.523-дзаасанавран хамгаалах тоноглолоортоноглогдсон байна.

(2) энэ бүлгийн (1)-д шаардсанавран хамгаалах тоноглолууд нь ИНД91.523(d) ба (e)-д -ийн холбогдох шаардлагуудад нийцсэн байна.

135.365Нөөц

135.367 Бүхээгийн дуу чимээ бичигч

Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд нислэгийн үйл ажиллагаандаа ашиглах нисдэг тэргийг бүхээгийн дуу чимээ бичигчээр тоноглогдсон байна:

(1) тухайн нисдэг тэрэгний Нислэг ашиглалтын зааварт хоёр буюу түүнээс дээш тооны нисэх багийн гишүүнтэй байхыг шаардсан; болон

(2) тухайн нисдэг тэрэг нь нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 10 буюу түүнээс дээш тооны суудалтай бол.

135.369Нислэгийн өгөгдөхүүн бичигч

Гэрчилгээ эзэмшигчийн нисдэг тэрэг нь нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 10 буюу түүнээс дээш тооны суудалтай бол энэ дүрмийн Хавсралт В В.4-ийн шаардлагад нийцсэн нислэгийн өгөгдөхүүн бичигчээр тоноглогдсон байна.

135.371 Нэмэлт авиагоризонт

Гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тийрэлтэт, эсхүл сэнст тийрэлтэт хөдөлгүүр бүхий агаарын хөлөг бүр нь гуравдагч нэмэлт авиагоризонтоор тоноглогдсон байна.

Г БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ

135.401 Техник үйлчилгээ

Энэ бүлэг нь ИНД 135-н дагуу үйл ажиллагаа явуулж байгаа агаарын хөлгийн техник үйлчилгээнд тавигдах шаардлагуудыг тогтооно.

135.402 Техник үйлчилгээний нөхцөл

(а) Гэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлгүүдийн техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах шаардлагуудыг тусгасан байна:

(1) ИНД 91.615-ийн дагуу жил тутам НТЧ-ыг дүгнэх; эсхүл

(2) ИНД 135.415-н дагуу жил тутам техник үйлчилгээг дүгнэх.

(b) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн удирдлага нь ИНД 119.124 (с)-ийн шаардлагад хамаарахгүй бол агаарын хөлөг тус бүрийн хувьд ИНД 91.615-ийн дагуу жил тутам техник үйлчилгээг дүгнэнэ.

(с) Гэрчилгээ эзэмшигч нь энэ бүлгийн (а)(2)-ийн дагуу техник үйлчилгээг дүгнэж байгаа үедонгоцны техник үйлчилгээг дараах байгууллагаар гүйцэтгүүлнэ:

(1) ИНД 145-ийн дагуу гэрчилгээжсэн ТҮБ-аар; эсхүл

(2) Монгол Улсаас өөр улсад техник үйлчилгээг хийлгэх болгэрээнд заасан нөхцлийн дагуу тухайн улсаас гэрчилгээжсэн ТҮБ-аар.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээжсэн дээд жин 5700 кг-с их эсхүл нисэх багийнсуудлыг тооцохгүйгээр 10 болон түүнээс олон зорчигчийн суудалтай нисдэг тэрэгний техник үйлчилгээг дараах байгууллагаар гүйцэтгүүлнэ:

(1) ИНД 145-ийн дагуу гэрчилгээжсэн ТҮБ-аар; эсхүл

(2) Монгол Улсаас өөр улсад техник үйлчилгээг хийлгэх бол гэрээнд заасан нөхцлийн дагуу тухайн улсаас гэрчилгээжсэн ТҮБ-аар.

135.403 Агаарын хөлгийн НТЧ-ыг хариуцах

(a) Гэрчилгээ эзэмшигч нь НТЧ-ийн дараах хариуцлагыг хүлээнэ:

(1) нислэгт ашиглаж байгаа агаарын хөлөг тус бүрийн хувьд: болон

(2) агаарын хөлөгт суурилагдсан болон холбогдсон бүх тоног төхөөрөмжүүдийн хувьд.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь ашиглаж байгаа агаарын хөлгийн техник үйлчилгээг ИНД 119.63 эсхүл ИНД 119.111-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

135.405 Бодит нөхцөлд тулгуурласан техник үйлчилгээний хөтөлбөр

(a) Гэрчилгээ эзэмшигч нь бодит нөхцөлд тулгуурласан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу агаарын хөлөгт техник үйлчилгээ хийж байгаа үед ИНЕГ-ын Даргад дараах зүйлийг агуулсан техник үйлчилгээний найдвартай ажиллагааны тайланг сар бүр хүргүүлнэ:

(1) агаарын хөлгийннийт нислэгийн цаг; болон

(2) агаарын хөлгийн НТЧ-тай холбоотой нисгэгчийн мэдээлэл; болон

(3) агаарын хөлгийн техникээс шалтгаалсан саатал, нислэг цуцлагдсан мэдээлэл; болон

(4) агаарын хөлгийн хөдөлгүүр агаарт гэнэт унтарсан мэдээлэл; болон

(5) хуваарьт бус хөдөлгүүр буулгасан мэдээлэл; болон

(6) хуваарьт бус эд анги сольсон мэдээлэл; болон

(7) эд анги тоног төхөөрөмж татгалзсан мэдээлэл; болон

(8) НТЧ-аас шалтгаалсан зөрчлийн мэдээлэл.

135.407 Нөөц

135.409 Нөөц

135.411Нөөц

135.413Нөөц

135.415Техник үйлчилгээг дүгнэх

(а) Гэрчилгээ эзэмшигч нь ИНД 135.402 (а)-ийн дагуу техник үйлчилгээний хөтөлбөрт заасан хүрээнд агаарын хөлгийн техник үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэхдээ дараах зүйлийг бататгана:

(1) хэрэв агаарын хөлгийн техник үйлчилгээний гүйцэтгэлийгөмнөх 12 сарын дотор дүгнээгүй бол тухайн агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

(2) агаарын хөлгийн техник үйлчилгээний гүйцэтгэлийг энэ хэсгийн (d) –д заасны дагуу дүгнэнэ.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь энэ хэсгийн (c)-д зааснаас бусад тохиолдолд агаарын техник үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэх явцдаа дараах зүйлийг заавал тооцно:

(1) агаарын хөлгийн маягийн гэрчилгээн дээр заасан үзүүлэлтүүд эсхүл ижил маягийн үзүүлэлтүүд нь ИНЕГ-ын Даргаас хүлээн зөвшөөрөгдсөн; болон

(2) агаарын хөлөг нь ИНД 91.509 (b)-н дагуу дараах ниссэн цаг бичигч төхөөрөмжөөр тоноглогдсон:

(i) ниссэн цаг бичигчийн мэдээллийг техник үйлчилгээний бүртгэлийн дэвтэр дээр бичдэг; болон

(ii) агаарын хөлгийн техник үйлчилгээний дэвтэр дээр бичигдсэн нийт цагийг ниссэн цаг бичигчийн мэдээлэлтэй харьцуулах; болон

(iii)энэ зүйлийн (b) (2) (ii)-д заасан зөрүү гарсан тохиолдолд ИНД 43.155 (a) (4)-д дагуу мэдээлснийг.

(3) хамгийн сүүлд техник үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэсэнээс хойш:

(i)хийгдсэн үндсэн өөрчлөлт болон засварууд зөв бичигдсэн ашигласан техникийн үзүүлэлтүүд нь ИНД 21 Хавсралт D-н жагсаалтад орсон байх; болон

(ii) тухайн өнгөрсөн хугацаанд техник үйлчилгээний хөтөлбөрт тусгагдсан техник үйлчилгээнүүд хугацаандаа бүрэн хийгдсэн байх; болон

(iii)ИНД 39-н дагуу гарсан холбогдох НТЧ-ын удирдамжууд хийгдсэн байх; болон

(iv) гарсан техникийн гэмтэл дутагдлын тухай мэдээлэл бүрэн бичигдсэн эсхүл тэдгээрийг засварласан эсхүл засварыг түр хойшлуулсан үйл ажиллагаа нь гэрчилгээ эзэмшигчийн заавар журмын дагуу хийгдсэн байх; болон

(v) агаарын хөлөгт техник үйлчилгээ хийж гүйцэтгэн нислэгт гаргасан үйл ажиллагаа нь ИНД 43 Бүлэг С-н дагуу хийгдсэн байна.

(с) Гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын Даргаас хүлээн зөвшөөрсөн, Чанарын дотоод баталгаажуулалтын хөтөлбөрийн байнгын мөрдөлтөнд үндэслэн техник үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэсэн тухай тэмдэглэл үйлдэж болох ба хөтөлбөрт дараах зүйлүүд тусгагдсан байна:

(1) техник үйлчилгээний гүйцэтгэлийн явцад энэ зүйлийн (b)-гийн шаардлагууд хянагдсан байх талаар; болон

(2) техник үйлчилгээний гүйцэтгэлийн дүгнэлт нь гэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлөг бүрийн хувьд хийгдэж баталгаажсан байх талаар.

(d) Гэрчилгээ эзэмшигчийн техник үйлчилгээний гүйцэтгэлийн дүгнэлт хийх ажилтан нь дараах шаардлагуудыг хангасан байна:

(1) техник үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэлтийг, тухайн агаарын хөлгийн маягийн хувьд дадлага туршлагатай, агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн мэргэжлийн үнэмлэхтэй эрх бүхий этгээд гүйцэтгэх; болон

(2) техник үйлчилгээний гүйцэтгэлийг энэ бүлгийн (b) эсхүл (c)-ийн дагуу хийж гүйцэтгэх; болон

(3) агаарын хөлгийн техник үйлчилгээний гүйцэтгэлийн дүгнэлтийг хийсний дараа дараах тэмдэглэлийг хийсэн байна:

Энэхүү агаарын хөлөгт болон түүний тоног төхөөрөмжид хийгдсэн Техник үйлчилгээний гүйцэтгэлийн дүгнэлт нь тэдгээрийн НТЧ-ыг хадгалах зайлшгүй шаардлагын үүднээс, ИНД135.415-ийн дагуу хийгдсэн болно. (Гарын үсэг _____ огноо _____)

НБҮЛЭГ. НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

135.5013орилго

Энэ бүлэг нь нисэх багийн гишүүдэд тавигдах шаардлагуудыг тогтооно.

135.503 Нисэх багийг томилох

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан этгээдийг нисэх багийн гишүүнээр томилж нислэгийн үйл ажиллагаанд оролцуулна:

(1) тухайн ажил үүрэгт тохирсон хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, зэрэглэлтэй; болон

(2) эрүүл мэндийн хүчин төгөлдөр 1-р ангиллын гэрчилгээтэй; болон

(3) нисэх багийн гишүүнд тавигдах дадлага туршлага, ур чадвар, туршлага, сургалтын холбогдох шаардлагуудыг хангасан; болон

(4) үйлдэх гэж буй нислэгийн бүх чиглэл болон аэродромын талаар зохих мэдлэгтэй.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь нислэг бүрт дараах этгээдийг томилсон байна:

(1) агаарын хөлгийн даргыг; болон

(2) хоёр ба түүнээс дээш тооны нисгэгч шаардлагатай бол туслах нисгэгчийг; болон

(3) гүйцэтгэх нислэгийн төрлөөс хамааран нисэх багийн бусад гишүүдийг.

135.505 Агаарын хөлгийн даргын дадлага туршлагад тавигдах шаардлагууд

(a) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн даргаар томилогдох этгээд нь тухайн загвар, маягийн агаарын хөлгийн хувьд нислэгийн дараах дадлага туршлагатай байхыг бататгана:

(1) нэг хөдөлгүүртэй агаарын хөлгөөр 5 цагийн нислэг, 5 удаагийн хөөрөлт буулт үйлдсэн; болон

(2) олон хөдөлгүүртэй агаарын хөлгөөр 10 цагийн нислэг, 10 удаагийн хөөрөлт буулт үйлдсэн; болон

(3) турбинт тийрэлтэт, эсхүл сэнст турбинт хөдөлгүүрт онгоцоор 15 цагийн нислэг, 10 удаагийн хөөрөлт буулт үйлдсэн.

(4) нэг нисгэгчтэй агаарын хөлгөөр ХНД эсхүл ИХНД-ээр шөнийн нислэг гүйцэтгэх бол:

(i) тухайн загвар, маягийн агаарын хөлгийн хувьд 40 цаг ниссэн байх; эсхүл

(ii) тухайн загвар, маягийн агаарын хөлгийн хувьд нэг нисгэгчтэй агаарын хөлгөөр ХНД эсхүл ИХНД-ээр шөнө ниссэн нислэгийн цаг нь энэ хэсгийн (a) (1), (a) (2), эсхүл (a) (3)-д заасан шаардлагыг хангасан байх.

(b) энэ зүйлийн (c) болон (d)-д шаардсан хангахын тулд ИНД 135.557-д заасан агаарын хөлгийн анхан шатны маягийн сургалт эсхүл ИНД 135.559-д заасан агаарын хөлгийн шилжин сургалтыг дуусгах болон ИНД 135.607-д заасан ур чадварын шалгалтыг өгсний дараа энэ дүрмийн (a)-д заасан дадлага туршлагыг дараах байдлаар тооцож эхэлнэ:

(1) агаарын үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нислэг; болон

(2) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд урьд нь ашиглагдаж байгаагүй агаарын хөлгийн хувьд, тухайн маягийн агаарын хөлөг дээр гүйцэтгэсэн шалгах нислэг, эсхүл техникийн нислэг; болон

(3) агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх этгээдэд хяналтанд тавих эрх бүхий багш нисгэгч нь:

(i) гэрчилгээ эзэмшигчээс агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж дадлага туршлага авах этгээдэд хяналтанд тавих эрх нь баталгаажсан; болон

(ii) хяналт тавих үедээ нисгэгчийн суудал суусан; болон

(4) энэ хэсгийн (а) (4) (i)-д заасан нислэгийн 40 цаг нь дараах зүйлээс бүрдэнэ:

(i) ХНД-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа бол ХНД-н дагуу 10-аас багагүй цаг нислэг гүйцэтгэсэн; эсхүл

(ii) шөнө ИХНД-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа бол 10-аас багагүй хөөрөл буулт шөнө гүйцэтгэсэн; болон

(5) энэ хэсгийн (а)-д заасан нислэгийн дадлага туршлагыг нислэгийн ур чадварын шалгалтыг амжилттай өгснөөс хойш 180 хоногийн хугацаанд хийсэн тохиолдолд тооцно:

(6) хэрэв нисгэгч нислэгийн дадлага туршлагыг энэ хэсгийн (5)-д заасны дагуу нислэгийн ур чадварын шалгалт өгөхөөс 180 хоногийн өмнө хийж чадаагүй тохиолдолд нисгэгч нь туршлагыг тооцохоос өмнө заавал нислэгийн ур чадварын шалгалт өгнө.

(с) энэ хэсгийн (а)-д заасан нислэгийн дадлага туршлагыг дараах байдлаар тооцно:

(1) энэ хэсгийн (а) (1), (а) (2) болон (а) (3)-д заасан нислэгийн цаг болон хөөрөлт буултын дадлагыг хэрэв ИНЕГ-ын Дарга хүлээн зөвшөөрсөн үед тохиолдолд нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэсэн нислэгийн цаг, хөөрөлт буултыг: болон

(2) хэрэв энэ хэсгийн (а)-д заасан нислэгийн цагийн дадлагыг агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхдээрх бүхий багш нисгэгчийн хяналтанд гүйцэтгэсэн бол дадлага туршлагад оруулж тооцно.

(d) хэрэв агаарын хөлөг нь 2 эсхүл түүнээс доош зорчигчийн суудалтай бол энэ хэсгийн (b) (1)-ийн шаардлага нь хамаарахгүй болно.

135.507 Нөөц

135.509 Нисгэгчид тавигдах шаардлагууд- ХНД-ийн дагуу үйлдэх нисэх

Гэрчилгээ эзэмшигч нь ХНД-ийн дагуу нислэг үйлдэх үед дараах шаадлага хангаагүй нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилохгүй:

- (1) нислэгийн нийт цаг нь 750-аас багагүй, түүний 150 цаг орон нутаг нисэхдээ 50 цагаас багагүй ХНД-ийн дагуу ниссэн дадлага туршлагатай; болон
- (2) 50 цаг бодитоор эсхүл 25 цаг нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэсэн; болон
- (3) 25 цаг шөнийн нислэг гүйцэтгэсэн.

135.511 Хамгийн цөөн нисэх баг- ХНД-ийн дагуу үйлдэх нислэг

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд нэг нисгэгчтэй агаарын хөлгөөр ХНД-ийн дагуу нислэг үйлдэхгүй:

- (1) тухайн агаарын хөлгийн Нислэг ашиглалтын зааварт нэг нисгэгчтэйгээр ХНД-ийн дагуу нислэг үйлдэхийг зөвшөөрөөгүй; болон
- (2) тухайн агаарын хөлөг автопилотгүй, эсхүл онгоцны хөндлөн ба дагуу тэнхлэгийн дагуу нислэгийн маневруудыг гүйцэтгэх болон өндрийг тогтмол бариулах автомат удирдлагагүй; болон
- (3) товчлуур нь агаарын хөлгийн даргын жолоон дээр суурилагдсан микрофон бүхий чихэвчгүй; болон
- (4) агаарын хөлгийн дарга энэ дүрмийн бусад шаардлагуудыг хангаагүй бол.

(b) Гэрчилгээ эзэмшигчийнагаарын хөлөг нь нисгэгч бүрийн хувьд аюулгүй ажиллагаа болон нислэгийн үйл ажиллагаанд шаардлагатай дараах тоноглолоор тоноглогдоогүй бол тухайн агаарын хөлгөөр 2 нисгэгчтэй нислэг үйлдэж болохгүй:

- (1) нисгэгч бүрийн хувьд агаарын хөлгийн бүх хэрэглэлүүд болон хөдөлгүүрийн мэдээллийг бүрэн хянах боломжтой; болон
- (2) нисэх багийн гишүүд ххарилцах дотоод холбооны төхөөрөмжтэй; болон
- (3) дор дурдсаны аль нэг:
 - (i) бүрэн ажиллагаатай хоёр удирдлагатай; эсхүл

(ii) хоёр нисгэгч хувьд хөндлөн ба дагуу тэнхлэгийн дагуу нислэгийн маневруудыг гүйцэтгэх болон хөдөлгүүрийн удирдлага нь тусдаа ажиллагаатай.

I БҮЛЭГ. СУРГАЛТ ДАДЛАГА

135.551 Зорилго

Энэ бүлэг нь нисэх багийн гишүүдийн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагуудыг тогтооно.

135.551 Ерөнхий зүйл

(a) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн ур чадварыг хадгалах, дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөртэй байна.

(b) Гэрчилгээ эзэмшигчийн нисэх багийн гишүүд нь энэ зүйлийн (a)-д заасан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт, дадлагад хамрагдсан байна.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавих үүрэгтэй.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь сургалтын хөтөлбөрөө:

(1) өөрөө бие даан хэрэгжүүлж болно; эсхүл

(2) ИНД141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалт, дадлагын байгууллагатай гэрээ байгуулж болно; эсхүл

(3) ИНД141-ийн стандарт шаардлагыг хангасан гадаадын сургалтын байгууллагатай гэрээ байгуулна.

135.555 Сургалт дадлагын бүртгэл тэмдэглэл

Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн хийсэн дадлага, сургалтыг нарийвчлан бичсэн бүртгэл тэмдэглэлтэй байна.

135.557 Нисэх багийн гишүүдийн анхан шатны сургалт

(a) Гэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлгийн нисэх багийн гишүүд анхан шатны сургалтыг дараах байдлаар хийсэн байна:

(1) тодорхой аргачлалын дагуу; болон

(2) дараах зүйлийг агуулсан сургалтын хөтөлбөрийн дагуу:

(i) онгоцны маягийн хувьд болон үйлдэх гэж буй нислэгт зориулан суурилуулсан тусгай тоноглолууд дээр;болон

(ii) үйлдэх гэж буй нислэгт ашиглах аэродромууд болон нислэгийн чиглэлүүдээр;болон

(iii) нисэх багийн гишүүдийн томилолт, үйл ажиллагаа, үүрэг хариуцлагын талаар;болон

(iv) нисэх багийн гишүүдэд зориулсан аврах тоноглолын байрлал, тэдгээрийн ажиллагааны талаар;болон

(v) хүчилтөрөгчийн тоноглолын байрлал, ашиглалтын талаар; болон

(vi) ердийн болон аврах гарц хаалга, аваарын гулсах шат болон олсны байрлал, ашиглалтын талаар; болон

(vii) гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагааны заавар, журмуудын талаар.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд сургалтын хөтөлбөрийг нисэх багийн гишүүн бүрийн хувьд өөрчилж болно:

(1) тухайн өөрчлөлт нь нисэх багийг гишүүдийн сургалт, дадлагын бүртгэл тэмдэглэлд бичигдэх бол; болон

(2) сургалт, дадлагын бүртгэл тэмдэглэлд бичигдэх өөрчлөлт түүний шалтгааныг гэрчилгээ эзэмшигч баталгаажуулсан бол.

135.559 Нисэх багийн гишүүдийн шилжин сургалт

(а) Гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагаанд нисэх багийн гишүүнээр үүрэг гүйцэтгэж байгаа болон бэлтгэгдсэн аливаа этгээд дараах тохиолдолд шилжин сургалтанд хамрагдана:

(1) нэг маягийн агаарын хөлгөөс өөр маягийн агаарын хөлөгт шилжих бол; эсхүл

(2) нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд шинэ нислэгийн журам мөрдөх, эсхүл шинээр тоноглолууд ашиглах бол.

(b) Шилжин сургалт нь дараах зүйлд чиглэсэн байна:

(1) тухайн агаарын хөлгийн маягт нийцсэн журам, аюулгүй ажиллагааны заавар журмууд болон аврах тоноглолуудын ашиглалт; болон

(2) нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд гарсан шинэ нислэгийн журам, эсхүл шинэ тоноглолуудыг судлах.

135.561 Давтан сургалт

Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн үйлдэж байгаа нислэгийн төрөл, гүйцэтгэж байгаа ажил үүрэг, агаарын хөлгийн хувьд тохирох сургалтад хамраглаж бэлтгэгдсэн, ур чадвартай байхыг бататгана.

135.563 Зорчигч тээвэрлэх үед хориглох нислэгийн маневр

(а) Гэрчилгээ эзэмшигч нь зорчигч тээврийн нислэгийн үед сургалтын зорилгоор хэвийн бус, онцгой байдлын дадлагын нислэгийн маневрхийхгүй байхыг бататгана.

(b) Энэ хэсгийн (а)-д заасан хэвийн бус, онцгой байдлын дадлагын нислэгийн маневр гэдэг нь дараах зүйлүүдээс бүрдэх бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

(1) агаарын хөлгийн хөдөлгүүр татгалзах үеийн нөхцөл үүсгэх хөдөлгүүрийн ажиллах зогсоох буюу багасгах;

(2) хөдөлгүүрүүдийг ижил бус зөрүүтэй ажлуулах;

(3) агаарын хөлгийн системүүд татгалзах, дүрст болон дуут дохиолол өгөх ба эдгээр нь зорчигчдод сонсогдох;

(4) агаарын хөлгийн системүүд татгалзахнь нислэгийн аюулгүй ажиллагаа алдагдахад хүргэх үйлдэл.

135.565 Нисэх багийн сургалтын хөтөлбөр

(a) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдэд зориулсан Сургалтын хөтөлбөртэй байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдэд зориулсан анхан шатны, шилжин болон давтан сургалтын шаардлагууд нь дараах зүйлд нийцсэн байна:

(1) тухайн нислэгт зориулсан тусгай тоноглол, агаарын хөлгийн маягт; болон

(2) үйлдэх гэж буй нислэгийн чиглэлүүд болон ашиглах аэродромуудад; болон

(3) гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагааны заавар, журмуудад.

(b) Газрын болон нислэгийн зохих зааварчилгыг шаардлагатай бол агаарын хөлөг дээр, эсхүл зөвшөөрөгдсөн нислэгийн дадлагажуур дээр өгөхөөр Сургалтын хөтөлбөрт тусгасан байна.

(d) Сургалтыг ИНД 135.567-ийн шаардлагыг хангасан багш нисгэгч удирдана.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн мэргэшлийн талаарх бүртгэл тэмдэглэлийг нисгэгч бүрийн хувьд үйлдэж хадгална.

135.567 Багш нисгэгчийн мэргэшлийн бэлтгэлд тавигдах шаардлага

Энэ дүрмийн дагуу багийн бусад гишүүдийн сургалт, дадлагыг удирдах багш нисгэгчид дараах шаардлага тавигдана:

(1) энэ бүлгийн шаардлагын дагуу, агаарын хөлгийн даргаар амжилттай бэлтгэгдсэн; болон

(2) А, В, С ангиллын багш нисгэгчийн зэрэглэлтэй; болон

(3) багш нисгэгчийн хамрагдсан байвал зохих анхан шатны болон давтан сургалтыг амжилттай дүүргэсэн.

J БҮЛЭГ. НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДИЙН УР ЧАДВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

135.601 Зорилго

Энэ бүлэг нь нисэх багийн гишүүдийн нислэгийн ур чадварыг хэрхэн үнэлэх зорилготой болно.

135.603 Ерөнхий зүйл

(а) Гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн шаардлагын дагуу, нисэх баг болон багийн бусад гишүүдийн нислэгийн ур чадварыг үнэлэх хөтөлбөрийн боловсруулж, хэрэгжилтэнд нь хяналт тавина.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) нислэгийн ур чадварыг үнэлэх хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлж болно; эсхүл
- (2) ИНД141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно, эсхүл
- (3) ИНД 141-ийн стандартыг хангасан гадаадын сургалтын байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

135.605 Шалгах нисгэгчийн бэлтгэл, ур чадвар

(а) Энэ зүйлийн (b)-ийн заалтыг үл харгалзан ур чадварыг үнэлэх хөтөлбөрийн дагуу нисгэгчийн нислэгийн ур чадварыг шалгах аливаа этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж буй агаарын хөлгийн маягийн хувьд зэрэглэлтэй; болон
- (2) гэрчилгээ эзэмшигчийн явуулж буй нислэгийн үйл ажиллагааны төрлүүдийн талаар мэдлэгтэй; болон
- (3) шалгах нисгэгчийн зэрэглэлтэй; болон
- (4) шалгах нисгэгчийн хамрагдсан байвал зохих анхан шатны болон давтан сургалтуудыг амжилттай дүүргэсэн.

(b) Энэ зүйлийн (а)-дзаасан дурьдсан нислэгийн ур чадварыг дадлагажуур дээр шалгаж байгаа шалгах нисгэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) энэ дүрмийн дагуу үйлдэх нислэгийн төрөлд агаарын хөлгийн даргаар ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн; болон
- (2) шалгах нисгэгчийн зэрэглэлтэй; болон
- (3) шалгах нисгэгчийн хамрагдсан байвал зохих анхан шатны болон давтан сургалтуудыг амжилттай дүүргэсэн.

135.607 Нисэх багийн гишүүдийн ур чадварыг шалгах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлийг бататгана:

- (1) агаарын хөлгийн даргын хувьд, өмнөх 12 сарын дотор шалгах нисгэгчийн хяналтан дор аэродромын болон чиглэлийн нислэгийн шалгалтуудыг амжилттай өгсөн байх ба үүнд:
 - (i) нислэгийн нэг бүтэн үед нислэг үйлдэх ба нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдах аэродромуудад нэгээс дээш буулт үйлдэх нислэгийн шалгалт; болон

(2) энэ дүрмийн дагуу гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг хариуцлагыг “хангалттай” гүйцэтгэж чадахаа харуулсан.

(2) **ИХНД-ээр нислэг үйлдэж байгаа нисгэгчийн хувьд** өмнөх 12 сарын дотор, онцгой нөхцөл байдлын үед мөрдөх журам болон бусад журмыг багтаасан ур чадварын шалгалтыг шалгах нисгэгчийн хяналтан дор, тухайн нисгэгч нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байсан агаарын хөлөгтэй ижил төстэй агаарын хөлөг дээр амжилттай өгсөн байх; болон

(3) **ХНД-ээр нислэг үйлдэж байгаа нисгэгчийн хувьд** өмнөх 6 сарын дотор шалгах нисгэгчийн хяналтан дор дараах шалгалтуудыг амжилттай өгсөн байх ба үүнд:

(i) онцгой нөхцөл байдлын үед тухайн агаарын хөлөгт суурилагдсан тоног төхөөрөмжтэй харцаж ажиллах дүрэм болон бусад журмууд, тухайн нисгэгчийн үйлдэх нислэгийн үйл ажиллагааны төрлүүдээр; болон

(ii) хоёр хөдөлгүүртэй, нисгэгчийн суудлыг тооцохгүйгээр 9 хүртэлх хүний суудалтай агаарын хөлгийн төрөл тус бүр дээр 6 сар тутамд нэг удаа; болон

(4) **нисгэгч бүрийн хувьд** өмнөх 12 сарын дотор дараах онолын шалгалтуудыг бичгээр, эсхүл амаар өгсөн байх:

(i) иргэний нисэхийн хууль, дүрэм, Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны заавар болон журмуудын талаарх мэдлэг;

(ii) тухайн нисгэгчийн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн системүүд, нислэг-техникийн өгөгдөхүүнүүд болон нислэгийн журмууд, хүлээн зөвшөөрөгдсөн нислэг ашиглалтын зааврын талаарх мэдлэг;

(iii) навигаци, НХУ, цаг уурын мэдлэг;

(iv) тухайн нислэгийн төрөлд хамааралтай тусгай нислэгийн талаарх үйл ажиллагааны талаарх мэдлэг;

(v) шинэ тоноглол, журам, арга ажиллагаа;

(vi) аврах тоног төхөөрөмжийн ажиллагаа ба байрлал;

(5) шалгах нисгэгч нь энэ хэсгийн (1), (2), (3), ба (4)-д заасан ур чадварын шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна:

(i) тухайн нисгэгчийн нислэгийн ур чадварын сургалтын үр дүнг сургалт дадлагын тайлан бүртгэлд тэмдэглэсэн байх; болон

(ii) хэрэв нисгэгчийн нислэгийн ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн бол тухайн нисгэгчийн дэвтэрт сургалтын үр дүнгийн талаар ИНД 61.29 (а) (3)-ийн дагуу тэмдэглэл үйлдэнэ.

(6) нисэх багийн ур чадварыг агаарын хөлөг, эсхүл энэ зорилгоор зөвшөөрөгдсөн нислэгийн дадлагажуур дээр жилд 2 удаа шалгасан байх.

135.609 Нөөц

135.611 Хүчингүй болгосон заалт

135.613 Шалгалтын бүртгэл тэмдэглэлийг хадгалах

Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн ур чадварын болон онолын шалгалтын бүртгэл тэмдэглэлийг байнга хадгална.

К БҮЛЭГ. НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ, АМРАЛТЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

135.801 Зорилго

Энэ бүлэг нь нисэх багийн гишүүдийн ажил, амралтын цагийн зохицуулалт талаарх шаардлагуудыг тодорхойлох зорилготой болно.

135.803 Гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлага

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэнэ:

(1) нисэх багийн гишүүдийн нислэгийн болон ажлын цагийн зохицуулалтыг тусгасан хуваарьтай байх; болон

(2) энэ зүйлийн (1)-д заасан хуваарь нь дараах зүйлүүдийг тусгасан байх:

- (i) нислэгийн өмнөх амралтын хугацаа;
- (ii) цагийн зөрүүд дасан зохицох;
- (iii) цагийн бүс;
- (iv) шөнийн нислэг;
- (v) нислэгийн хамгийн их тоо;
- (vi) нэг нисгэгчтэй нислэг;
- (vii) хоёр нисгэгчтэй нислэг;
- (viii) хоёр нисгэгч болон нивэх багийн бусад гишүүд;
- (ix) нисэх багийн гишүүдийн мэргэшлийн бэлтгэл;
- (x) хамтатгасан ажил үүрэг;
- (xi) нисгэгч, үүрэг гүйцэтгэхийн өмнө буюу дараа зорчигчийн журмаар аялах;
- (xii) нөөц болон бэлэн байх үе;
- (xiii) нислэг дэх ажил үүргийн үе;
- (xiv) нислэгийн үед амрах;
- (xv) нислэгийн үйл ажиллагааны төрөл;
- (xvi) ажлын нийт цаг;
- (xvii) нислэгийн нийт цаг;
- (xviii) ажлын ба нислэгийн цагийн нэмэгдүүлж болох хувилбар;
- (xix) биоритм;
- (xx) амралтын өдрүүд;
- (xxi) бүртгэлийн хадгалалт.

(3) энэ хэсгийн 1/-д заасан хуваарид дараах шаардлагыг тусгасан байна:

- (i) нисэх багийн дараалсан 30 хоногийн дотор 160-аас дээш цаг нисэхгүй байх;

(ii) нисэх баг аливаа 14 хоногийн дотор 2-оос доошгүй өдөр амрах;

(iii) нисэх баг нь аливаа 30 хоногийн дотор үргэлжилсэн 4-өөс доошгүй өдөр амрах.

(4) энэхүү хуваарь нь ИНЕГ-ын Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн аль нэг гишүүн нислэгийн нөхцөл байдлаас болж нислэгийн явцад ядарч туйлдаж болзошгүйг мэдэж байгаа, эсхүл ингэж үзэх бодит шалтгаан байгаа бөгөөд энэ нь нислэгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлнө гэж үзэж байвал тухайн нисэх багийн гишүүнийг нислэгийн үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзана.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаа явуулж байгаа бол дараах үүрэг хүлээнэ:

(1) нислэг үйлдэж байгаа нисэх багийн гишүүдийн нислэгийн цагийн үнэн зөв бүртгэлийг; болон

(2) энэ зүйлийн (c) (1)-д заасан бүртгэл тэмдэглэлийг хийгдсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгална.

135.805 Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага

(a) Нисэх багийн гишүүд нь нислэг үйлдэх нөхцөлөөс хамаарч тус тусын үүрэг хариуцлагыг ойлгосон байх ба ядарч болзошгүй гэж үзэж буй тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцохоос татгалзах үүрэгтэй.

(b) Нисэх багийн гишүүн нь Гэрчилгээ эзэмшигчид гэрээгээр ажиллаж байгаа үедээ нислэгийн өөр үйл ажиллагааг шан хөлсөөр гүйцэтгэх, эсхүл ИНД 135.803(a)(1)-д заасан нислэгийн болон ажлын цагийн хязгаарлалтыг хэтрүүлэхийг хориглоно.

(c) Аливаа этгээд ИНД 135.803(a)(1)-д заасан хязгаарлалтууд хэтрээгүй гэдгийг тодорхойлоод агаарын хөлгийн нисэх багийн гишүүнээр томилогдохыг хориглоно.

(d) Энэ дүрмийн (c)-д заасныг үл харгалзан хүний эрүүл мэнд эсхүл аюулгүй ажиллагааг хангах зорилгоор нислэг үйлдэх гэж байгаа агаарын хөлгийн ахмад нь цагийн хязгаарлалт хэтэрсэн нь тухайн нислэгт нөлөөлөхгүй гэж үзсэн үед нислэгийг гүйцэтгэж болно.

L БҮЛЭГ. ЗААВАР, НИСЛЭГИЙН ДЭВТЭР БОЛОН БҮРТГЭЛ

135.851 Зорилго

Энэ бүлэг нь нислэгийн үйл ажиллагаатай холбоотой заавар, нислэгийн дэвтэр болон бүртгэлүүдийг хадгалахад тавигдах шаардлагуудыг тодорхойлох зорилготой болно.

135.853 Үйл ажиллагааны мэдээлэл

Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагааны зааврын нисэх багийн гишүүдийн ажил үүрэгт хамааралтай хэсэг нь хүчин төгөлдөр бөгөөд нисэх багийн гишүүд ашиглах боломжтой байхыг бататгана.

135.855 Агаарын хөлгийн бүхээгт авч явах бичиг баримтууд

Гэрчилгээ эзэмшигч нь нислэг үйлдэх агаарын хөлөг нь нислэг бүрдээ дараах бичиг баримтыг авч явна гэдгийг бататгана:

- (1) нислэгт шаардлагатай NOTAM мэдээ болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний баримт бичиг; болон
- (2) цаг агаарын мэдээ; болон
- (3) аюултай ачааны мэдээлэл; болон
- (4) нислэгт холбогдол бүхий нислэгийн зураг, схемийн хувь, хуулбарууд.

135.857 Нислэгийн өдөр тутмын бүртгэл

(а) Гэрчилгээ эзэмшигч нь өдөр тутмын нислэгийн талаарх дараах зүйлийг багтаасан нарийвчилсан бүртгэлийг агаарын хөлөг бүрийн хувьд өөр байдлаар хадгалах хэдий ч тухайн нислэг бүрийн хувьд дэлгэрэнгүй бүртгэлийг тодорхой загварын дагуу бүрдүүлж хөтөлнө.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь өдөр тутмын нислэгийн талаарх дараах зүйлийг багтаасан бүртгэлийг хөтөлнө.

- (1)
- (2)
- (3)
- (4)
- (5)
- (6)
- (7)
- (8) нисэх буудлын талаархи мэдээлэл;
- (9) нислэгийн дугаар эсхүл хөөрөх цаг;

(10) агаарын хөлгийн хоосон жин, тоноглолуудын жин, нислэгт шаардлагатай хангамжийн материалуудын нийт жин болон нисэх багийн нийт жин;

(11) нийлбэр жин -

(i) зорчигчдын нийт жин; болон

(ii) нислэгт шаардлагатай хангамжийн материалуудын нийт жин; болон

(iii) нийт ачааны жин.

(12) нийт хэрэглэх түлш:

(13) хөөрөлтийн жин:

(14) агаарын хөлгийн төвлөрөлтийн тухай мэдээлэл:

(15) хоосон үеийн жин, хөөрөлтийн жин, буултын жинг тооцсон нислэгийн үйл ажиллагааны хамгийн их жин:

(16) ИНД 135.303 (f)-д заасан заалтыг хэрэглэсэн тухай мэдээлэл:

(c) Гэрчилгээ эзэмшигч нь нислэг бүрийн өмнө (b)(11)-ээс (b)(15)-д заасан мэдээллүүдээр агаарын хөлгийн даргыг цаг хугацаанд нь бүрэн хангаж, нисгэгч нь ИНД 135.305 (b)-д заасны дагуу агаарын хөлгийн жин ба төвлөрөлтөнд үнэлгээ заавал өгсөн байхыг бататгана.

135. 859 Бүртгэлийг хадгалах

(a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн төлөвлөгөө болон аюултай ачааны талаарх бүртгэл мэдээллийг нислэг үйлдсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хугацаанд хадгална.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн нислэгийн болон ажлын цагийн бүртгэлийг бүртгэл хийсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгална.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн сургалт, дадлага, шалгалтын тайлан, бүртгэлийг тухайн нисэх багийн гишүүн гэрчилгээ эзэмшигчтэй гэрээгээ цуцалснаас хойш 12 сар хүртэл хугацаагаанд хадгална.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь өдөр тутмын нислэгийн бүртгэлийг нислэг үйлдсэн өдрөөс хойш 12 сараас доошгүй хугацаанд хадгална.

ХАВСРАЛТ А. НӨӨЦ

ХАВСРАЛТ В. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НТЧ-ЫН СТАНДАРТ

В.1 Нөөц

В.2 Нөөц

В.3 Бүхээгийн дуу чимээ бичигч


Бүхээгийн дуу чимээ бичигч нь:

- (1) АНУ-ын Техникийн стандарт TSO-ын C84 серийн, эсхүл C123 серийн шаардлагад нийцсэн; болон
- (2) АНУ-ын Техникийн стандарт TSO-ын C121 серийн шаардлагын дагуу усан дор байрлал тодорхойлох төхөөрөмжөөр тоноглогдсон; болон
- (3) нислэгийн сүүлчийн 30 минутаас багагүй хугацааны үргэлжилсэн бичлэг хийх чадвартай байна.

В.4 Нислэгийн өгөгдөхүүн бичигч

Нислэгийн өгөгдөхүүн бичигч нь:

- (1) АНУ-ын Техникийн стандарт TSO-ын C124 серийн шаардлагыг хангасан; болон
- (2) АНУ-ын Техникийн стандарт TSO-ын C121 серийн шаардлагын дагуу усан дор байрлал тодорхойлох төхөөрөмжөөр тоноглогдсон; болон
- (3) нислэгийн 8 цагийн мэдээллийг тоон хэлбэрээр бичиж хадгалах боломжтой байх ба уг мэдээлэл нь арилгах боломжгүй; болон
- (4) MEL-д зааснаас бусад дор дурдсан параметруудийг бичнэ:
 - (i) Зураг 1-д заагдсан; болон
 - (ii) Хавсралт Б-гийн Хүснэгт 1, эсвэл Хүснэгт 2-т заасан.



Зураг 1. Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн шийдвэрийн хүснэгт



Хүснэгт 1. ИНД 135 - Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн параметрт тавигдах шаардлагууд

Хүснэгт 2-д заасан агаарын хөлгийн параметруудийг уншиж байгаа тохиолдолд харгалзах тодорхойлолтуудын нүдийг энэ Хүснэгт 1-д тодруулсан. Энэхүү хүснэгтэд ИНД 135.369-ын шаардлагууд тусгагдсан болно.

(A)

(B)

Parameter	23 Parameter Helicopter	25 Parameter Helicopter
1	Time	Time
2	Airspeed	Altitude
3	Altitude	Airspeed
4	Heading	Heading
5	Vertical acceleration	Vertical acceleration
6	Longitudinal acceleration	Pitch attitude
7	Pitch attitude	Roll attitude
8	Roll attitude	Radio transmitter keying
9	Attitude rate	Power in each engine: Free power turbine speed and engine torque
10	Main rotor speed	Main rotor speed
11	Free or power turbine for each engine	Attitude rate
12	Engine torque for each engine	Pilot input – primary controls
13	Primary hydraulic pressure	Flight control hydraulic pressure low
14	Secondary hydraulic pressure (if	Flight control hydraulic pressure selector switch

	available)	position. 1 st and 2 nd stage
15	Radio transmitter keying	AFCS mode and engagement status
16	Autopilot engaged	SAS status – engaged
17	SAS status – engaged	SAS fault status

Хүснэгт 1. ИНД 135 - Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн параметрт тавигдах шаардлагууд

Агаарын хөлгийн параметруудийг Хүснэгт 2-с уншиж байгаа тохиолдолд харгалзах тодорхойлолтуудын нүдийг энэ Хүснэгт 1-д тодруулсан. Энэхүү хүснэгтэд ИНД 135.369-ын шаардлагууд тусгагдсан болно.

(A)

(B)

Parameter	23 Parameter Helicopter	25 Parameter Helicopter
18	SAS fault status	Main gearbox temperature low
19	Collective	Main gearbox temperature high
20	Pedal position	Controllable stabilator position
21	Lateral cyclic	Longitudinal position
22	Longitudinal cyclic	Lateral acceleration
23	Controllable stabilator position	Master warning
24		Nav 1 and Nav 2 frequency selection
25		Outside air temperature

Хүснэгт 2. ИНД 135 - Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн параметрийн тодорхойлолтууд

Энэхүү хүснэгтэд ИНД 135.369-ын шаардлагууд тусгагдсан болно.

Parameters	Range	Installed system minimum accuracy (to recovered data) ¹	Sampling interval (per second)	Resolution read out ²
Relative time (from recorder on prior to takeoff)	25 hr minimum 24 hours	±0.125% per hour	1 0.25	1 sec
Indicated airspeed	V _{min} to v _d (KIAS) (minimum airspeed signal attainable with installed pitot/static system) As the installed measuring system	±5% or ±10 knots, whichever is greater ±3%	1	1 kt.
Attitude	-1,000 ft to 20,000 ft pressure altitude -1,000 ft to max certificated altitude of aircraft	±100 to ±700 ft (see Table 1, TSO C51-a)	1	25 to 150 ft 5` to 30`
Magnetic heading	360°	±5° ±2°	1	1° 0.5°
Vertical acceleration	-3 g to +6 g	±0.2 g in addition to ±0.3 g maximum datum	4 (or 1 per second where peaks, ref. to 1g are	0.05 g

		±1% of max range excluding datum error of ±5%	8	0.1g
Longitudinal	±1.0g	±1.5% max. range excluding datum	2	0.03g

Хүснэгт 2. ИНД 135 - Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн параметрийн тодорхойлолтууд

Энэхүү хүснэгтэд ИНД 135.369-ын шаардлагууд тусгагдсан болно.

Parameters	Range	Installed system minimum accuracy (to recovered data) ¹	Sampling interval (per second)	Resolution read out ²
		Error of ±5%	4	0.01g
Lateral Acceleration	±1.0 g	±1.5% max, range excluding datum error of ±5%	4	0.01g
Pitch attitude	100% of usable	±2°	1	0.8°
	±75°		2	0.5°
Roll attitude	±60° ±100% of usable range, whichever is greater	±2°	1	0.8°
	±180°		2	0.5°
Attitude rate	±8,000 fpm	±10% Resolution 250 fpm below 12,000 ft indicated As installed	1	250 fpm below
	±6,000 fpm		2	12,000 0.2%
Engine power each engine				
Engine power each engine Main rotor speed	Maximum range	±5%	1	1% of full range
	0-130%	±2%	2	0.3% of full range

Free or power turbine	Maximum range 0-130% (power Turbine Speed)	±5% ±2%	1 (per engine)	1% of full range 0.2% to 0.4% of full range
Engine torque	Maximum range	±5% ±2%	1 (per engine)	1% of full range 0.2% to 0.4% of full range

Хүснэгт 2. ИНД 135 - Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн параметрийн тодорхойлолтууд

Энэхүү хүснэгтэд ИНД 135.369-ын шаардлагууд тусгагдсан болно.

Parameters	Range	Installed system minimum accuracy (to recovered data) ¹	Sampling interval (per second)	Resolution read out ²
Flight Control – Hydraulic Pressure				
Hydraulic Pressure Low	Discrete, each circuit		1	
Hydraulic Pressure Selector Switch Position, 1 st and 2 nd Stage	Discrete		1	
Primary (discrete)	High/low		1	
Secondary – if applicable (discrete)	High/low		1	
Avionics				
Radio transmitter keying (discrete)	On/off		1	
Autopilot engaged (discrete)	Engaged or disengaged		1	
AFCS Mode and Engagement	Discrete (5 bits necessary)		1	
SAS status – engaged (discrete)	Engaged/disengaged		1	
SAS fault status (discrete)	Fault/OK		1	

			0.25	
--	--	--	------	--

Хүснэгт 2. ИНД 135 - Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн параметрийн тодорхойлолтууд

Энэхүү хүснэгтэд ИНД 135.369-ын шаардлагууд тусгагдсан болно.

Parameters	Range	Installed system minimum accuracy (to recovered data) ¹	Sampling interval (per second)	Resolution read out ²
<i>Flight Controls</i>				
Collective	Full range	±3%	2	1% of full range 0.5% of
Pedal position Selection	Full range	±3%	2	1% of full range 0.5% of
Lateral cyclic	Full range	±3%	2	1% of full range 0.5% of
Longitudinal cyclic	Full range	±3%	2	1% of full range 0.5% of full range
Controllable stabilator position	Full range	±3%	2	1% of full range 0.4% of full range

Main Gearbox Temperature Low	As installed	As installed	0.25	0.5% of full range
Main Gearbox Temperature High	As installed	As installed	0.5	0.5% of full range

Хүснэгт 2. ИНД 135 - Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн параметрийн тодорхойлолтууд

Энэхүү хүснэгтэд ИНД 135.369-ын шаардлагууд тусгагдсан болно.

Parameters	Range	Installed system minimum accuracy (to recovered data) ¹	Sampling interval (per second)	Resolution read out ²
Master Warning	Discrete		1	
Nav 1 and Nav 2 Frequency Selection	Full range	As installed	0.25	
Outside Air Temperature	-50 °C to +90°C	±2°C	0.5	0.3°C

Notes:

1. When data sources are aircraft instruments (except altimeters) of acceptable quality to fly the recording system excluding these sensors (but including all other characteristics of the recording system) shall contribute no more than half of the values in this column.
2. This column applies to aircraft manufactured after October 11, 1991.

ХАВСРАЛТ С. ХӨӨРӨХ, БУУХ ЗУРВАС (ХБЗ)

Энэхүү хавсралт нь ИНД 135.77-ын шаардлагад хамаарна.

С.1. ХБЗ-ны хамгийн бага өргөн

ХБЗ-ны хамгийн бага өргөнийг тодорхойлохдоо Хүснэгт 1-ийг ашиглан тухайн онгоцны маягт тохирох Аэродромын лавлах код (ARC)-ыг тодруулна. ARC нь онгоцны оврын хэмжээ, нислэгийн үзүүлэлтэд хамааралтай хоёр элементээс бүрдэнэ. Элемент 1 нь Аэродромын талбайн урт (ARFL)-д үндэслэсэн тоо ба Элемент 2 нь онгоцны размах болон үндсэн гадна дугуйн хоорондын зайд үндэслэсэн үсэг байна.

С.1.1. Хүснэгт 2-ыг ашиглан ARC-ийг тодорхойлох

(a) **Нэгдүгээрт:** Онгоцны нислэг үйлдэх аэродромын талбайн уртыг тодорхойлно. Тэрхүү талбайн урт нь нислэгийн заавраас авсан зурвасны хазайлт нь "0", тогтуун агаарт, далайн түвшин дэх агаарын стандарт нөхцөлд тухайн онгоцны хамгийн их хөөрөлтийн жинтэй хөөрөлт үйлдэх хамгийн бага талбайн урт юм.

(b) **Хоёрдугаарт:** Аэродромын талбайн уртаар элемент 1-ийн тоон кодыг тодорхойлох; болон

(c) **Гуравдугаарт:** Онгоцны размах болон үндсэн гадна дугуйн хоорондын зайн хэмжээний хамааралтайгаар элемент 2-ын үсгэн кодыг олно (Жишээ, хэрэв үсгэн код С нь онгоцны размах-д хамааралтай, үсгэн код D нь онгоцы үндсэн гадна дугуйн хоорондын зайд хамааралтай байхад тухайн онгоцны маягийн хувьд D үсгэн кодыг сонгоно.)

Хүснэгт 1. Аэродромын лавлах код (ARC)

Элемент 1- ийн код		Элемент 2- ийн код		
Code Number	Аэродромын талбайн урт (ARFL)	Үсгэн код	Далавчны размах	Үндсэн гадна дугуйн хоорондын зай
1	800 м-ээс бага	A	14,99 м хэртэл	4,5 м хүртэл
2	800м – 1200 м хүртэл	B	15м : 23,99 м хүртэл	4,5м: 5,99 м хүртэл
3	1200м- 1800 м хүртэл	C	24м : 35,99 м хүртэл	6м: 8,99 м хүртэл
4	1800 м- ээс илүү	D	36м : 51,99м хүртэл	9м : 13,99 м хүртэл
		E	52 м : 65 м хүртэл	9 м : 14 м хүртэл

С.1.2 Хүснэгт 2-ыг ашиглан ХБЗ-ны хамгийн бага өргөнийг тодорхойлох

Онгоцны ARC-ыг тодорхойлсон тохиолдолд, тухайн ХБЗ-ны өргөнийг зохих тоон код, үсгэн код хоёрын огтлолцлоор тодорхойлно. Жишээ нь, хэрэв онгоцны ARC нь 2С бол шаардлагатай зурвасын өргөн нь 30 м байна.

Хүснэгт 2. ХБЗ-ны өргөн

Тоон код	Үсгэн код				
	A	B	C	D	E
1	18 м	18 м	23 м	-	-
2	23 м	23 м	30 м	-	-
3	30 м	30 м	30 м	45 м	-
4	-	-	45 м	45 м	45 м

С.1.3 Нислэгийн талбайн хамгийн бага өргөн

(хүчингүй заалт)

